МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,102.853... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.09.02. Баасан. №155 (4525) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

Э.ЭНХБАЯР: ҮНДЭСНИЙ ХӨЛӨГ ОНГОЦНЫ БАГ БҮРДҮҮЛЖ, ЭХ ОРНЫХОО БАРААГ ТЭЭВЭРЛЭХИЙГ ХҮСДЭГ

II нүүрт

**ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА**

65 ЖИЛИЙН ТҮҮХТ МУБИС-ИЙН ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЛОО

IV нүүрт

**АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ**



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Г.ЭРДЭНЭБАТ:

### ДАГАЛДАХ ХУУЛИУДЫГ БАТЛААГҮЙ ЦАГТ ЭРҮҮ БОЛОН ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ ХЭРЭГЖИХ ЯМАР Ч БОЛОМЖГҮЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

Дугаарын 60 мөр

## Ядаж шинжилгээг нь үнэгүй болгочих

Б.ДАВАА

Есдүгээр сарын 1 боллоо. Энэ өдөр оюутан сурагчдын хувьд хамгийн их хүсч хүлээдэг өдөр байх. Харин манай гэр бүлийн хувьд юутай ч зүйрлэх аргагүй тийм нэгэн гуниг харууслын өдөр байдаг юм. Одоогоос яг дөрвөн жилийн өмнө тулах ганц багана болсон “ханхар уул” нурж байлаа. Айлын хүн өвдсөн гэнэ гэж сонсч байснаас биш, өөрт тохиолдоно гэж зүүдлээ ч үгүй явсан элэгний хорт хавдар өвчнөөр хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн хадам эцгээ уултай зүйрлэн ингэж бичлээ. Одоо бидний дэргэд тэр хүн үгүй. Түүний хоосон орон зай сэтгэлд үгүйлэгдсэн хэвээрээ л байна. Чимээгүй өвчилж, хүнд шатанд орсон хойноо л илрэх элэгний хорт хавдрын улмаас өнчрөл хагацал үзсэн бидэнтэй адилхан гэр бүл Монголд цөөн биш шүү. Одоо ч төрөл төрөгсөд, танилын хүрээнд элэгний хавдартай, гал унтраах байдлаар түр аргацаасан эмчилгээ хийлгэж, өдөр хоногийг өнгөрүүлж яваа хүн олон байна. Анагаах ухаан хөгжсөн өнөө үед өвчинд шаналсан нэгнээ зүгээр харж байгаад нүдэн дээрээ үхүүлж чадахгүй учир хамаатан саднаараа халаасаа хоосолж байгаа дүр зураг эргэн тойронд өрнөсөн хэвээр.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Н.ПУНЦАГБОЛД

### Б.Нэргүй: Ерөнхийлөгч хувийн хэрэгцээ, хоол хүнсэндээ төсвөөс нэг ч төгрөг зарцуулж байгаагүй

Засгийн газраас төсөв хэмнэх мэдэгдэл гаргаж, өндөр цалин дарга нарын цалинг хасах талаар ам ангайсан. Үүнтэй зэрэгцээд тэр дарга ийм цалин авдаг, тийм хангамж эдэлдэг гэх худал, үнэн нь мэдэгдэхгүй мэдээлэл цахим ертөнцөөр “тэнүүчлэх” болсон. Тэр дундаа Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өдрийн хоолны төсөв 1.3 сая төгрөг гэх ч мэдээлэл гарсан билээ. Тэгвэл энэ талаар Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд дарга, Ерөнхийлөгчийн төсвийн шууд захирагч Б.Нэргүй тайлбар хийжээ. Тэрбээр “Юуны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн шууд захирагчийн хувьд өөрийн тань асуултад хариуцлагатайгаар хариулт өгье. Би Монгол Улсын Ерөнхийлөгчийн албанд найм дахь жилдээ ажиллаж байна.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**







ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 3000 SERIES



БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ

Inspiron 3000 загварын авсаархан, хөнгөхөн нөутбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан HD LED дэлгэц, Intel® процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

Онцгой урамшуулал

Dell брэндийн 3000 серийн нөутбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.

www.facebook.com/PCmallOfficial
www.instagram.com/PCmall_Official

Биднийг дагаарай

7575-3535



Бэлгэнд
• Үүргэвч
• 2 жилийн баталгаа
• McAfee вирусын програм

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8


| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2200.00 | 2228.00 | ФУНТ | 2849.00 | 2954.00 |
| ЕВРО | 2434.00 | 2506.00 | РУБЛЬ | 31.70 | 36.20 |
| ИЕН | 21.12 | 21.78 | ЮАНЬ | 325.00 | 332.80 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2200.00 | 2233.00 | ФУНТ | 2825.00 | 2960.00 |
| ЕВРО | 2396.00 | 2513.00 | РУБЛЬ | 32.24 | 35.76 |
| ИЕН | 20.77 | 21.85 | ЮАНЬ | 324.00 | 334.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



# Э.ЭНХБАЯР: ҮНДЭСНИЙ ХӨЛӨГ ОНГОЦНЫ БАГ БҮРДҮҮЛЖ, ЭХ ОРНЫХОО БАРААГ ТЭЭВЭРЛЭХИЙГ ХҮСДЭГ

Н.БАТЗАЯА

Монгол далайд гарцтай орон. Ингэж хэлбэл та “Монгол чинь далайд гарцгүй орон шүү дээ” хэмээн гайхаж байж магадгүй. Гэвч манай орон аль хэдийн гүн цэнхэр далайд хөл тавьж, улсынхаа далбаан дор хөлөг онгоцны тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж эхлээд 10 гаруй жил болжээ. Тодруулбал, далайд гарцгүй орон олон улсын усан тээврийн зах зээлд компани байгуулан эх орныхоо далбаан дор хөлөг онгоцны тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг гэсэн үг. Ингэснээр далайд гарцгүй орнууд өөрийн далбаагаар их тэнгист хөл тавих боломжтой болж байгаа юм. Энэхүү үйл ажиллагаа анх 2003 онд Зам тээврийн яамны дэргэд “Далайн захиргаа” гэх байгууллага үүссэн өдрөөс эхэлсэн түүхтэй. Тус байгууллага нь үндэсний хөлөг онгоц, багийн гишүүдтэй болж эх орныхоо экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг далайгаар тээвэрлэх эрхэм зорилготой аж. Одоогийн байдлаар далайн тээвэрлэлт, хөлөг онгоц бүртгэл, дотоодын усан замын тээвэр, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, боомт ашиглах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Тэр дундаа мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн анхаарч ажилладаг байна. Энэ хүрээнд БНСУ-ын “Далайн тээвэр, загас ан агнуурын институт”-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан 2013 оны гуравдугаар сард тус улсад нийт 10 оюутанг хөлөг онгоцны хөдөлгүүрийн инженер, удирдлага жолоодлогын чиглэлээр сургажээ. Эдгээр оюутны дөрөв нь сургуулиа амжилттай төгссөн бөгөөд тэдний нэг Э.Энхбаяр БНСУ-ын эзэмшлийн “Jupiter Ace” хөлөг онгоц дээр есөн сарын хугацаатай ажиллах хөдөлмөрийн гэрээ байгуулсан аж. Тэгвэл түүнийг их далайн аянд үдэж өгөх үйл ажиллагаа өчигдөр Чингис хаан олон улсын нисэх буудалд боллоо. Энэхүү үйл ажиллагаанд Далайн захиргааны дарга Х.Энхбаатар болон гэр бүл, найз нөхөд нь оролцсон юм. Энэ үеэр Далайн захиргааны дарга Х.Энхбаатар “Үе үеийн засгийн газраас далайн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэхийг эрмэлзэж, үүнд анхаарч ажиллаж байсан. Тухайлбал, өмнө нь бид ОХУ-д мэргэжилтэн бэлтгэдэг байлаа. Сүүлийн үед далайн салбарт тэргүүлэгч улстай хамтарч ажиллахыг зорьсон. Энэ хүрээнд МУ-ын Засгийн газар, БНСУ-ын засгийн газартай санамж бичиг байгуулан, далайн тээвэр, боловсон хүчин бэлтгэхэд хамтарч ажиллаж байна. Бид ирээдүйн далайчин, туслах далайчин бэлтгэхэд ихээхэн анхаарч, хамтран ажилладаг. 2013 оноос эхлэн боловсон хүчнээ бэлтгэж эхэлсэн. 2013-2014 онд 10, 2014-2015 онд хоёр оюутан бэлтгэлээ. Энэ жил буюу 2017-2018 онд дөрвөн оюутан бэлтгэхээр төлөвлөөд байгаа. Эдгээр оюутнууд Солонгос улсын тэтгэлгээр суралцдаг. Манай улсад хүмүүс сонирхлоороо далайн чиглэлээр хувиараа суралцдаг тохиолдол бий. Манай байгууллагад Щвед, ОХУ, Солонгос, Майлтад төгссөн мэргэжлийн далайчид ажиллаж байна. Бид 2003 оноос эхлэн хөлөг онгоцны бүртгэлийн ажил хийсэн. Үүнээс гадна далайн тээвэрлэлт, далайн боомтын үйл ажиллагаа явуулах боломжтой гэдгийг мэдсэн. Тиймээс энэ чиглэлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхийг зорьж байгаа. Эдгээр бэлтгэгдсэн хүмүүс далайд ажиллах боломж, бололцоо бидэнд бий” гэв. Мөн тэрбээр, Монгол Улсад далайчид бий. Гэхдээ Э.Энхбаяр мэргэжлийн сургуулийг нь төгссөн Монголын анхны мэргэжилтэй албан ёсны далайчин гэдгийг онцолж байв. Монголын анхны далайн мэргэжлээр бэлтгэгдсэн боловсон хүчин хөлөг онгоцон дээр ажилласнаар цаашид манай улс үндэсний багтай болох эхлэл тавигдаж байгаа юм. Түүний ажиллах “Jupiter Ace” хөлөг онгоц одоогоор Өмнөд Африкаас хөдлөн Бразил улс руу тээвэрлэлт хийхээр явж байгаа аж. Э.Энхбаяр онгоцондоо Бразил улсаас суух аж. Мөн түүнтэй хамт БНСУ-д далайн чиглэлээр суралцаж буй Б.Далайбаяр, Х.Баярбат нар дадлагажигчаар хамт явсан. Энэ үеэр түүнийг онгоцондоо суухаас өмнө урьдаж хэдэн хором ярилцсан юм.

**-Юуны өмнө танд баяр хүргэе. Монголын анхны мэргэжлийн далайчин болж, хөлөг онгоцон дээр ажиллахаар шийдсэн гэлээ. Сэтгэл их хөөрч, догдолж байгаа болов уу?**

-Баярлалаа. Маш их догдолж, баярлаж байна. Би их далайд гарч, хөлөг онгоцон дээр ажиллахаар шийдсэн. Надад мөрөөдөл, зорилго бий. Түүнийгээ биелүүлэхийн төлөө явах гэж байна.

**-БНСУ-д олон мэргэжилтэн бэлтгэсэн гэсэн. Таны хувьд ямар мэргэжлээр суралцсан бэ?**

-Би анх Зам тээврийн яамны Далайн захиргаанаас энэ талаархи мэдээлэл авч байсан. Тэгээд 2013 онд анхны элсэгчээр суралцаж, төгссөн. Далайн хөдөлгүүрийн инженер мэргэжлээр суралцсан.

**-“Jupiter Ace” хөлөг онгоцон дээр өмнө дадлагаа хийж байсан гэсэн?**

-Тийм. Би ганцаараа 10 сар дадлага хийж байлаа. Тухай үед ганцаараа болохоор бэрхшээлтэй зүйл тулгарч байсан. Гэхдээ хийх ажлын хувьд монгол залуус бусад орны залуучуудаас дутаад, нялцганаад байдаггүй. Бусдын адил л хийдэг. Ганц зүйл нь гэвэл таньж мэдэх хүнгүй ганцаараа байсан юм. Одоо өөрөө мэргэжлээрээ ажиллах гэж байна. Дээр нь хоёр залуу дадлагажигчтай хамт явна. Тэгэхээр гурвуулаа учраас ханьтай байна гэсэн үг. Дараа жил дахиад дөрвөн залуу боловсон хүчин ирж, дадлагажина. Тэгэхээр долуулаа болно. Дадлага хийж байхдаа нийт 14 орноор тээвэрлэлт хийсэн.

**-Хөлөг онгоцны хөдөлгүүрийн гуравдугаар зэргийн инженер гэж ямар мэргэжил вэ. Энэ талаар тайлбарлаж өгөхгүй юу?**

-Ер нь хөлөг онгоц машинтай ойролцоо. Гэхдээ тавцангийн, хөдөлгүүрийнх гэж хоёр хуваагддаг. Тавцангийн баг ачаа буулгах, тээвэрлэлт хийдэг. Машинаар бол жолоодлогыг хариуцдаг гэсэн үг. Харин хөдөлгүүрийн багийнхан онгоцны амин сүнс болсон моторын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг. Хөлөг онгоцны мэргэжил багийн хамтын ажиллагаа байдаг. Энэ хоёр багийн хамтын хүчээр хөлөг онгоц явдаг. Бид дөрөв, дөрвөн цагаар ээлжилж ажилладаг. Тухайлбал, би өглөөний 08:00 цагаас өдрийн 12:00 цаг, оройн 20:00 цагаас шөнийн 00:00 цаг хүртэл ажиллана. Хоногт найман цаг жижүүрлэдэг. Хөдөлгүүрийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хянаж ажиллах юм. Бид Индонезийн багийнхантай цуг гарна. Капитан болон Чип инженерүүд нь солонгос хүмүүс. Нийт гурван орны хамтарсан баг ажиллах юм.

**-Залуу хүний хувьд олон зүйлийг хүсч мөрөөдөж энэ шийдвэрийг гаргасан байх. ирээдүйд ямар зүйл хийхийг хүсч мөрөөдөж байна вэ?**

-Манай улсын хувьд далай шинэ салбаруудын нэг. Энэ салбарт монгол улс бүрэн гарах боломжтой. Хамгийн гол зорилго гэвэл Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг монгол залуучууд Монголын хөлөг онгоцоор гуравдагч орон руу тээвэрлэхийг хүсч байна. Үүнд өөрийн зүгээс тусалж, илүү сайн мэргэжлийн боловсон хүчин болохыг зорьдог. Миний зорилго нэгэнт далайтай холбогдсон. Бид өөрсдөө тээвэрлэх бүрэн боломжтой гэдгийг л үзүүлмээр байна. Монгол залуусын тэнгисийн нэгдсэн полот нээгээд өөрсдөө бие дааж тээвэрлэлт хийх л миний зорилго. Их далай маш сайхан. Хөх тэнгэр гэдэг шиг хөх тэнгис бол эр хүний хийморийг сэргээсэн сайхан газар. Мөн өөрийн гэсэн далайн багтай болтлоо ажиллана. Далайн салбар маш өргөн хүрээтэй учраас дэд бүтцийн тал дээр ч гэсэн бүх зүйлийг сайн сураад Монголдоо ирж ажиллахыг зорьдог.

**-Далайчдад дээд боловсролоос гадна ямар шалгуур тавьдаг юм бэ?**

-Далайчин хүнд эрүүл мэнд маш чухал. Мөн олон улсын далайд гарах учраас хэл хэрэгтэй. Бидний хувьд БНСУ-д сургууль төгссөн учраас солонгос хэлээр ярьж чадна. Тэгэхээр хэлний шаардлагыг хангадаг гэсэн үг. Тавигдах шаардлага нь эрүүл мэнд, Солонгос болон Англи хэлний мэдлэг байдаг. Мөн дээд боловсролтой байвал сайн гэж үздэг.

**-Хөдөлмөрийн үнэлгээний хувьд ямар байдаг вэ?**

-Гуравдугаар зэргийн инженер 2700-3000 ам.долларын цалинтай.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

Дугаарын 60 мөр

## Ядаж шинжилгээг нь үнэгүй болгочих

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Ерөнхийдөө сүүлийн 10 жилд элэгний хавдрын нас баралт Монгол Улсад улам бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд жилд 1900 гаруй хүн оношлогддог гэсэн сэтгэл сэрдхийлгэм тоо баримт байна. Түүнчлэн, Монгол Улс дахь жилийн нийт нас баралтын 15 хувийг зөвхөн элэгний эмгэгийн нас баралт дангаараа эзэлж байна. Өөрөөр хэлбэл, нэг хоногт долоон хүн элэгний эмгэгээр нас барж, өдөрт долоон гэр бүл өнчрөл хагацал үздэг гэсэн үг юм. Энэ үзүүлэлтээрээ бид аль хэдийнэ дэлхийд цойлж явна. 100 мянган хүн тутам дахь элэгний хавдрын нас баралтаар дэлхийд манайх нэгдүгээрт бичигдэх болжээ. Өвчлөл өндөр байгаатай холбоотойгоор бид энэ өвчнийг үүсгэгч вирүсүүд хүний биед байдаг, байх ёстой мэт бодоцгоох болж. Тэр дундаа халдварт шар өвчнөөр өвчилсөн хүн л элэгний вирүстэй, өвчлөөгүй хүн вирүсгүй гэх бичигдээгүй хууль ч амьдралд үйлчилж байх шиг. Гэтэл халдварт шар өвчнөөр өвчлөөгүй ч, архаг В, С, Д вирүст хепатитын халдвартай хэн нэгнээс цусаар, бэлгийн замаар, шприэнээс халдвар авсан 400 гаруй мянган хүн бидний дунд амьдарч байна. Шүдээ эмчлүүлэх, зүү төөнүүр тавиулах, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх гэх мэт ямар нэг байдлаар архаг В, С, Д вирүсийн халдвар дамжсаар байдаг аж. Гуравхан сая хүн амтай. Тэднээс насанд хүрсэн хүн нь хоёр сая хүрэхтэй үгүйтэй байгаа манай улсад 400 мянга гэдэг бол дэндүү ахадсан тоо. Хамгийн харамсалтай нь тэдний 70 хувь нь халдвартай гэдгээ огт мэддэггүй байх юм. Элэгний В, С вирүсийн халдвар дамжих явцыг ДОХ-той адилтгаж болно. Гэхдээ архаг С хепатит вирүс ДОХ-оос 10 дахин хурдан, В вирүс 100 дахин илүү халдварламтгай бэлгийн замын халдварт өвчинд тооцогддог гэдгийг тэр бүр мэдэхгүй. Үүгээрээ ДОХ-той адил аюулт өвчин юм. Нэгэн үе С, В хепатит вирүс эмчилгээгүй байв. Харин анагаах ухааны хөгжлийн явцад С вирүсийг устгах боломж бүрдсэн, В вирүсийн халдвараас сэргийлэх вакцин ч гарлаа. Гэхдээ үнэ нь иргэдийн халаасыг тэмтчинэ. Ийм үед төрөөс иргэдийн эрүүл мэнд рүү чиглэсэн бодлого өгүүлэгдсээр байгааг нуугаад яах вэ. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр манайд ДОХ-ын халдвартай 200 орчим хүн бүртгэгдсэн байна билээ. Тэдний эмчилгээ, оношилгоог 100 хувь төрөөс даана. Харин тэрхүү өвчнөөс ч илүү өргөн тархалттай байгаа В, С, Д хепатит вирүсийн эсрэг эмчилгээнд бодитой хөнгөлөлт үзүүлж чадахгүй л байна. Хонгилын үзүүрт гэрэл харагдана гэгчээр Оном сангаас санаачлан хэрэгжүүлж буй элэгний өвчлөлтэй тэмцэх хөтөлбөр шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт суусан байна билээ. Энэ оны төсвийн тодотголд элэгний С вирүсийн эмчилгээг Эрүүл мэндийн даатгалд хамруулж, 40 хувиар хөнгөлөхөөр 23.4 тэрбум төгрөгийг суулгасан гэсэн ганц эерэг мэдээ бий. Үүндээ 30 мянган хүнийг хамруулна гэж тооцсон гэх. Гэвч дэндүү чамламаар юм. Зика, Эбола гэх мэт хаа хол дуулдах вирүсийн халдварлал, ДОХ-оос үхтлээ айх хэрнээ аль хэдийнэ айл бүрт шургалчихсан элэгний өвчлөлийг хөсөр хаясаар. Засгийн газраас айл бүрээ элэг бүтэн байлгахын төлөө дорвитой өөрчлөлт хийхийн төлөө ажиллах л гэж байгаа юм бол элэгний эмийн хөнгөлөлтөө 80 хувь болгочихооч. Эс бөгөөс ядаж вирүс илрүүлэх шинжилгээг нь үнэгүй болгоод өгөөч, гишүүд ээ.

МЭДЭЭЛЭЛ

# Н.НОМТОЙБАЯР: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРТ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ ХИЙНЭ

Монгол Улсын мэргэжлийн боловсрол сургалтын салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 91 Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж өчигдөр шинэ хичээлийн жилийнхээ нээлтийг хийж шинэ суралцагчдаа хүлээж авлаа. Энэ хичээлийн жилд МСҮТ болон Политехник коллежид хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай 193 мэргэжлээр залуусыг сургах бөгөөд тэдний нэг Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн хичээлийн шинэ жилийн нээлт “Эрдмийн баяр”-т УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр болон БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Т.Сureш Бабу нар оролцов.

Монгол Улсын нийгэм, эдийн засагт тэр дундаа хөнгөн үйлдвэр, урлал урлахуйн салбарын хөгжлийн түүчээ болсон ур чадвартай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж ирсэн 50 жилийн түүхтэй Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн багш сурагчдад УИХ, Засгийн газрын өмнөөс хичээлийн шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлж Н.Номтойбаяр сайд үг хэллээ. Тэрбээр сургуулийн хамт олонд амжилт хүсч хэлсэн үгэндээ хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй мэргэжилтнүүд нь МСҮТ төгсөгчид байдаг хэрнээ мэргэжлийн боловсролын сургуулийн нэр хүнд, сурч буй оюутан залуус, багш, ажилтнуудын үнэ цэнэ төдийлөн сайн үнэлэгдэхгүй байгаа нь энэ салбарт бодлогын томоохон шинэчлэл хийх цаг нь болсныг онцолсон. Тэрбээр энэхүү шинэчлэлийн хүрээнд юуны өмнө ажил олгогч талын бодлогыг сургалтын бодлоготойгоо уялдуулах замаар залуус ажил олгогчийн захиалгын дагуу суралцаад төгсөөд шууд ажлын байртай болдог байхын хамт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт төгсөгчдөд хувиараа ажил хөдөлмөр эрхлэхэд бизнесийн гарааны дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэхээр заасныг хэрэгжүүлэх, МСҮТ, политехник коллеж төгсөөд тодорхой хугацаанд мэргэжлээрээ ажилласан залуусыг их дээд сургуульд суралцахад мэргэжлийн боловсролын сургуульд сурсан хугацаанд үзсэн хичээлийг нь кредит цагт тооцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг үндсэн таван чиглэлд тодорхой ажлуудыг хийхээ дуулгасан юм.

1965 онд нийтийн ахуй үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх үндсэн үүрэгтэйгээр байгуулагдсанаас хойш 45 мянган мэргэжилтнийг бэлтгэсэн тус сургууль энэ хичээлийн жилд хамгийн олон буюу 32 мэргэжлээр 600 гаруй суралцагч элсүүлснээр нийтдээ 1300 орчим оюутан сурагчтай сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлж буйг захирал Б.Даваажав танилцуулаад Бүгд Найрамдах Энэтхэг улсын буцалтгүй 2,8 сая ам.долларын тусламжаар сургалтын материаллаг баазаа сайжруулж, 2016-2017 оны хичээлийн жилд гагнуур, хэвлэлийн ажилтан, үйлдвэрийн цахилгаан, электрон техник, мехатроник мэргэжлийн орчин үеийн шинэ тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон лабораториуд, хичээл, дадлагын байртай болж залууст суралцах таатай орчныг бүрдүүлснээ “Эрдмийн баяр”-ын үеэр онцолж байлаа.

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллеж улс, орны хөгжлийн түлхүүр болсон гар урлал, үйлдвэрлэл, үйлчилгээний 30 гаруй мэргэжлээр ерөнхий боловсролын сургуулийн ес болон арванхоёрдугаар анги төгсөгчдөөс гадна насанд хүрэгчдийг 1-3 жилийн хугацаанд сургаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцсэн ур чадвар эзэмшүүлэн төгсгөж байна. Тус сургууль хичээлийн хоёр байр, 300 оюутны дотуур байр, номын сан, биеийн тамирын танхимтай. Мэргэжлийн болон мэдээлэл технологийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон лаборатори, дадлагын газрууд бүхий сургалтын иж бүрэн орчинтой тус сургуулийн суралцагчид төгсөөд өөрөө өөртөө ажлын байр бий болгож чадах хэмжээнд бэлтгэгдэж буй нь хамгийн том давуу тал. Тухайлбал, үсчин, гоо засалч, оёдолчин зэрэг мэргэжлээр төгсөгчид нь 100 хувь ажлын байртай болдгийн багагүй хувь нь өөртөө ажлын бай бий болгоод зогсохгүй ажил олгогч болж чаддаг тухай нээлтийн ёслолын үеэр ярьж байлаа. “Эрдмийн баяр”-т оролцсон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт тус сургуулийнхан БНЭУ-аас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд байгуулсан зарим мэргэжлийн лаборатори, дадлагын газруудаа танилцуулж, суралцагчдынхаа хийсэн бүтээлийг сонирхуууллаа.

# ҮЗЭЛ БОДОЛ

## ХЭН ЮУ ХЭЛЭВ









**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Энэ хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэр бүлд болон хувийн хэрэгцээ, хоол хүнсэнд нь төсвөөс нэг ч төгрөг зарцуулж байгаагүй, тийм зардал ч төлөвлөгдөж тусгагддаггүй юм. Харин ч Монгол Улсын Ерөнхийлөгч бидэнд зардлаа багасгаж, төсвөө бодитой төлөвлөж, аль болох хэмнэлттэй ажиллах чиглэлийг байнга өгч ажилласнаар Ерөнхийлөгчийн төсөв жилээс жилд буурч байгаа шүү дээ. Үүнийг ойлгомжтой болгохын тулд ганцхан тоо хэлье л дээ. 2016 оны төсвийг 2013 оныхтой харьцуулахад бид нийт төсвөө 2, 3 дахин бууруулж чадсан. Үүнийг жил жилийн Төсвийн тухай хуулиас үзэж болно. Харин Монгол Улсын Төрийн тэргүүний хувьд гадаад, дотоод арга хэмжээний үеэр зочид, төлөөлөгчдөд барих зоогийн төсөв бий. Түүнийг батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулдаг. Энэ дашрамд ний нуугүй хэлэхэд зочдод барьсан зоог, хоолны зардлаа Ерөнхийлөгч хувиасаа төлчихдөг тохиолдол зөндөө л байдаг. Иймд олон нийтийн сүлжээгээр явуулж байгаа Ерөнхийлөгч өдөрт 1,3 сая төгрөгийн хоолны төсөвтэй гэсэн худал мэдээлэл, гүтгэлгээ зогсоох хэрэгтэй. Нөгөө талаас иргэд ийм мэдээлэлд итгэх хэрэггүй юм" хэмээн ярьсан байна.

### Ц.Оюунгэрэл: Зовлон шаналал, зодуур, хүүхдийн нулмсаар бичигдсэн хуулийг буцааж татлаа

УИХ-ын ээлжит бус чуулганаар таван хуулийн төслийг буцаан татах шийдвэр гаргасан билээ. Тэр дунд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль багтсан юм. Монголд гэр бүлийн хүчирхийлэл газар авч, жилээс жилд нэмэгдэж байхад энэ хуулийг эргүүлэн татсан нь олон хүнийг бухимдуулж байгаа билээ. Тэгвэл энэ асуудлаар УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр "Ардчилсан парламенттай Монгол Улсын түүхэнд батлагдсан хуулийг буцааж татсан тохиолдол байхгүй. Тэр тусмаа хүний эрхийг хамгаалах заалтуудтай хуулийг буцааж татсан түүх үгүй. Хүний эрхийн маш олон дэвшилт гарсан, хүний эрхийг бүх талаас нь хамгаалах цогц тогтолцоотой хуулиудыг хэрэгжүүлэхээс татгалзаж, батлагдсаны дараа татаж авч байгаа хар түүх энэ удаагийн парламентад гарлаа. Иймээс 2016 оны наймдугаар сарын 30-ны өдрийг хүний эрхийн түүхэнд хараар бичигдэх өдөр гэж үзэж байгаа юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль бол олон хүний амь нас, зовлон, шаналал, зодуур, хүүхдийн нулимсаар бичигдсэн хууль шүү дээ. Энэ хуулийг АН-ынхан бичээд АН-ынхан баталчихсан гэж МАН-ынхан эндүүрч боджээ. Уучлаарай тэгээгүй. Энэ хуулиуд бол аль нэг намын үзэл суртлаар бичигдсэн хууль биш. Энэ бол хүмүүнлэг сэтгэлээр бичигдэж намын харьяалалхаргалзахгүйбүхэмэгтэй гишүүд дэмжиж баталсан хууль юм. Батлагдсаны дараа эрэгтэй, эмэгтэй хөгшин залуу бүх хүмүүс эрх зүйн шинэчлэлийг бушуухан хэрэгжээсэй гэж хүлээж байсан. Гэтэл гэмгүй царайтай, цагаан цамц өмсөөд, зангиа зүүсэн нөхөд харгис үйлдэл хийлээ. С.Бямбацогт гэдэг хүн гадна талдаа сайдын төрхтэй боловч дотор талдаа хар харгис зүйлийг хийж чаддаг хүн гэдгээ харууллаа. Түүний өргөн барьсан хар тогтоолыг эсэргүүцэх чадалтай гишүүн МАН-д ганц ч байхгүйд харамсаж байна. Энэ бол эмгэнэлтэй явдал" хэмээн ярьжээ.

### Д.Оюунхорол: Орхон голыг бохирдуулж байгаа аж ахуйн нэгжийн асуудалд онцгой анхаарч эхэлсэн

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт алт олборлож буй компаниудын буруутай үйл ажиллагаанаас болж Монголын хамгийн урт гол болох Орхон бохирдоод байгаа билээ. Хэдхэн жилийн өмнө бас ийм явдал гарч байсан. Гэтэл өнөө жил Орхон голыг бохирдуулсан явдал давтагдлаа. Энэ талаар БОАЖ-ын сайд Д.Оюунхорол ярьсан байна. Тэрбээр "Архангай аймгийн Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж Орхон голыг бохирдуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн асуудалд бид онцгой анхаарал хандуулж эхэлсэн. БОАЖЯ, УУЯ, МХЕГ-ын хамтарсан ажлын хэсэг болон орон нутгийн Байгаль орчны газар удаа дараа шалгалт хийж, тэдгээр аж ахуйн нэгжүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгч байгаа боловч төрийн байгууллагуудын шаардлагыг үл ойшоож, үйл ажиллагаагаа урьдын адил хууль зөрчиж явуулсаар байна. Орхон голын эхэнд олборлолт явуулж буй 15 аж ахуйн нэгж байгууллагын хоёроос бусад нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл хийлгээгүй, нэгээс бусад нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө төвлөрүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулах техник, эдийн засгийн үндэслэл нь одоо болтол батлагдаагүй байгаа тул байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах боломжгүй байгаа. Энэ шаардлага, албан бичгээ тухайн аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох эрх нь зөвхөн мэргэжлийн хяналтын байгууллагад байдаг. Гэвч байдал өөрчлөгдөхгүй, ужгирсан байдалтай байгаа учраас асуудлыг илүү өргөн хүрээнд хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн. Энэ долоо хоногийн сүүлээр Цэнхэр сумын Орхон багийн ард иргэд, тэнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Архангай, Өвөрхангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, орон нутгийн удирдлага, БОАЖЯ, УУЯ, МХЕГ-ынхны хамтарсан өргөн хэлэлцүүлгийг бид газар дээр нь зохион байгуулах гэж байна. Хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө бүгдээрээ ажиллаж, хамтын хүчээр асуудлыг шийднэ" хэмээжээ.

### Ц.Цогтбаяр: Олимпийн тосгонд Д.Дагвадоржтой мэндлэхэд муухай харчихаад л явсан

Монголын Чөлөөт бөхийн холбоо дотроо хагаралтай, эрэгтэй тамирчдаа ялгаварлан үздэг хэвээрээ байгааг өнгөрч байгаа долоо хоногт болсон үйл явдал харууллаа. Монголын хоёр дасгалжуулагч тамирчнаа өмгөөлж, дэвжээн дээр хувцсаа тайлж челленж шидсэн үйлдлийг Монголын Чөлөөт бөхийн холбооноос бүдүүлэг үйлдэл гэж үзэж байгаа аж. Тиймээс Ц.Цогтбаяр, Б.Баяраа нарын дасгалжуулах эрхийг хассан шийдвэр гаргаснаа мэдэгдсэн юм. Түүний дараа дасгалжуулагч нар нөхцөл байдал ямар байгаа талаар, Чөлөөт бөхийн холбооны Ерөнхийлөгч Д.Дагвадорж ямар хандлагатай байгааг ярьсан юм. Ц.Цогтбаяр дасгалжуулагч "Монголын эрэгтэй чөлөөт бөхийн тамирчдын чадвар чансаа сүүлийн жилүүдэд эрс дээшилж байгаа. Тэр дундаа 2015 оны дэлхийн аваргаар найман жингийн тав нь дэлхийн аваргын медалийн төлөө барилдсан. Гурав нь медаль авч, хоёр нь шагналт тавдугаар байрт орж байсан. Бидний хоорондын атаа жөтөө, тэмцэл юунаас болоод үргэлжлээд яваад байгааг би ойлгохгүй байна. Өнгөрсөн жилийн буюу Чөлөөт бөхийн Олимпийн эрх олгох дэлхийн аваргын тэмцээний өмнө МЧБХ-ны Ерөнхийлөгч гээд байгаа Д.Дагвадорж гэдэг нөхөр шигшээ багийн дөрвөн багшийг шүүхэд өгсөн. Бид тэмцээний өмнө шүүх дээр өнжиж байсан. Найм, есдүгээр сард бид байнга шүүх, цагдаагаар явсан. Заримдаа аргаа барахдаа бусад багш нарт хүүхдүүдээ захиж үлдээдэг байлаа. Тийм учраас л бид Чөлөөт бөхийн холбоо эрэгтэй тамирчдын амжилтад ямар ч хамааралгүй шүү гэж хэлж байсан юм. Түүнээс хойш, хүн бүр сэтгэлээ өгч байгаа Олимпийн наадмын өмнө холбоо бидэнд тусалсан бил үү. Ирж уулзаагүй, утсаар яриагүй. Олимпийн бэлтгэлд гарчихсан байхад "Олимп" баазад ирж уулзсан нэг ч хүн байгаагүй. Риод Олимпийн тосгонд очоод, Д.Дагвадорж гэдэг нөхөртэй мэндэлэхэд муухай харчихаад л яваад өгсөн. Бид яах юм бэ. Айдастай байна шүү дээ бид. Дээрээс нь, миний ойлгож байгаагаар Г.Мандахнаран луйвардуулна, Монгол Улс медаль авахгүй юм байна гэдгийг Д.Дагвадорж, н.Баянмөнх, шүүгч Төмөрбаатар нар эрт мэдсэн. Яагаад гэвэл, эрэгтэй тамирчдын дөнгөж хоёр нь барилдсаны дараа Д.Дагвадорж "Бүх юм зүйл дууслаа. 0-ээс нь эхлэх хэрэгтэй юм байна" гэж мэдэгдсэн. Гэтэл цаана нь дөрвийн дөрвөн сайхан залуу барилдах гээд үлдсэн байсан шүү дээ. Энэ чинь юу гэсэн үг вэ. Дээрээс нь баг тамирчдаа хаяад явчихсан" хэмээн ярьсан юм.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч

## Цахиагийн ЭЛБЭГДОРЖ

**...Õ¿¿õäèéã áàãàañ íü, ñàéí ¿åýñ íü ýõýëæ ñàéí ñàíààòàé áàéëãàõ á¿õ ë ñàéí ñàéõíû ¿íäýñ áîë îþóí ñàíàà þì. Áè òýãæ èòãýäýã ø¿¿. ×è õ¿íèé òóõàé ìóó þì áîäîîä ýõýëáýë òýð çààâàë á¿ðòãýãäýã ãýæ áîäîîã....**



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## БАРИЛГЫН САЛБАРЫГ ДЭМЖИЖ, ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Н.БАТЗАЯА

Засгийн газраас улс орны эдийн засаг хоосорч, цаашид бүсээ чангалах хэрэгтэй гэдгийг мэдэгдэн, төрийн алба хаагчдыг цомхотгон, элдэв халамжийг хасч танан, ипотекийн зээлийг ч олгохгүй гэх асуудлыг хэлэлцэн иргэдийг багагүй сандралд оруулаад буй. Үүнтэй зэрэгцээд царцсан барилгууд олширч, шинээр баригдсан барилга байгууламж эздээ хүлээн барилгын салбар зогсонго байдалд ороод байга гэхэд хэлсдэхгүй. Тэгвэл ажлаа хүлээж аваад удаагүй байгаа Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр салбарынхантайгаа "Туушин" зочид буудлын хурлын танхимд өчигдөр уулзаж, шийдэх тулгамдсан асуудал, баримтлах бодлогынхоо талаар хэлэлцлээ.

Тэрбээр, уулзалтын эхэнд барилгын салбарын өнгөрсөн алдаа оноог хэлээд цаашид яамнаас хэрэгжүүлэх бодлогын талаар танилцуулсан. Энэ тухай "Хэд хэдэн чухал ажлыг хэрэгжүүлнэ. Нийслэл болон орон нутагт баригдаж буй барилгуудад хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдал хөндөгдөж байгаа. Үүнийг бид бүгд мэднэ. Барилга барих үед, барьсны дараа ч шатах тохиолдол гардаг. Тиймээс энэ байдлаас гарах боломцоог хайж байна. Энэний тулд байгалийн чулуугаар дулаалгын материал барьдаг үйлдвэрүүдийг бий болгоно. Энэ чиглэлийн үйлдвэрүүд нь чулууг боловсруулж хөвөн гаргаж авдаг. Байгалийн чулуугаар хийсэн хөвөн нь галд тэсвэртэй. Одоо бол барилгын дулаалгын материалд хөөсөнцөрийг ашиглаж байна. Тиймээс нэн тэргүүнд байгалийн чулуугаар дулаалгын материал хийх үйлдвэрийг дэмжин, дотооддоо ажиллана. Цаашилбал, гадаадад гаргахыг төлөвлөж байна" гэсэн юм. Мөн салбар яам ирэх дөрвөн жилд түрээсийн орон сууцны хөтөлбөрийг татан буулгахаас илүү дэмжиж ажиллахад анхаарах гэнэ. Ингэхдээ аймгуудад түрээсийн орон сууцны ашиглалт, хамгаалалтыг хариуцуулах бөгөөд орон сууцанд орох, ашиглалт, засвар, зээлийг аймгийн Засаг дарга нар хариуцан ажиллах юм байна. Харин нийслэлд түрээсийн орон сууцыг нэмж барихгүй бөгөөд баригдсан барилгын ашиглалтад анхаарч ажиллана гэдгийг онцолж байлаа. Түүнчлэн ипотекийн зээлийг үргэлжүүлэхэд анхаарч ажиллана гэдгээ ч дурьдсан. Энэ үеэр барилгын салбарт олгогдсон зээлийн талаар ч танилцуулсан. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд "Үнэ тогтворжуулах хөтөлбөр"-ийн хүрээнд орон сууцны барилгыг тогтворжуулах ажилд 534.5 тэрбум төгрөгийн зээлийг 101 компанид өгчээ. Цемент арматурын үнийг тогтворжуулахад 55 компанид 125.4 тэрбум төгрөг, барилгын материалын үйлдвэрлэлийг эргэлтэд гаргахад 69 компанид 170 тэрбум төгрөгийг зээлээр олгосон байна. Эдгээр зээлийг 2014 оноос эхлэн импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжих ажлын хүрээнд барилгын материалын 30 гаруй үйлдвэрийн төслийг Чингис бондын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлсан аж. Мөн 2015 онд барилгын үйл ажиллагаа, барилгын угсралт, барилгын зураг төслийн чиглэлээр 4500 гаруй тусгай зөвшөөрөлтэй компани бүртгэгджээ.

**Үргэлжлэл нь VII нүүрт**

## ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# 65 жилийн түүхт МУБИС-ийн ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЛОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Э.ТУУЛ

2016-2017 оны хичээлийн шинэ жилийн нээлт өчигдөр Монгол орон даяар эхэлж, хонхны дуу цангинан, оюутан залуус шуугилдан эрдмийн их өргөө “амь орлоо”. Зуны зугаатай бас амралтын урт өдрүүд ийнхүү дуусч, эрдэм номдоо шамдан суралцах их үйлсийн гараагаа эхлүүлэх өдрүүд айлчлан ирж байгаа нь энэ. Монгол Улсын их дээд сургуулиудад элсэн суралцагчид ч энэ өдөр сэтгэл догдлон, оюутан болох агшнаа хүлээн зогсох ажээ. Энэ жил улсын хэмжээнд 100 их, дээд сургууль, коллежид 164 500 оюутан суралцагч элссэнээс МУБИС-д 3000 орчим оюутан хичээлийн шинэ жилээ эхлүүлж байгаа аж. Түүнчлэн 2016-2017 оны хичээлийн жилд МУБИС-ийн бакалаврын төвшинд 13 мянга, магистр, докторын төвшинд 2000 гаруй оюутан суралцаж байгаа бөгөөд энэ хичээлийн жилд 23 мэргэжлээр 3000 орчим оюутан шинээр элсээд байгаа гэнэ. Манай сурвалжлах хэсэг энэ жил үүсэн байгуулагдсаныхаа түүхт 65 жилийн ойтойгоо золгож буй Монгол Улсын Боловсролын их сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагааг онцлон сурвалжиллаа. Энэ хичээлийн шинэ жилийн нээлт олон онцлог үйл явдлаар дүүрэн байлаа. Тухайлбал, Рио-2016 Олимпийн наадмын мөнгө, хүрэл медальт хоёр тамирчин оюутнаараа гоёсон, бахархсан, түүхт 65 жилийн ой тохиосон, харьяа шинэ цэцэрлэгээ нээсэн зэрэг үйл явдал дүүрэн хичээлийн шинэ жилийн ёслолын ажиллагаа ийнхүү эхлэв. Мөн 2016-2017 оны хичээлийн жилд 500 гаруй оюутан 70, 52 оюутан 100, МУБИС-ийн "Оюутныг дэмжих" сангийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэгт 45, “Хаан” банкны тэтгэлэгт долоо, “Bank of China”-ын тэтгэлэгт дөрвөн оюутан тус тус хамрагдан, дөрвөн жил сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэн суралцахаар болжээ. Тус сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаанд УИХ-ын дарга М.Энхболд, БСШУС-ын сайд Ж.Батсуурь, МУБИС-ийн захирал, доктор профессор Д.Мөнхжаргал, Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэн, МУБИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор профессорЛ.Цэрэнсодном, Сургалт хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд профессор, доктор Х.Тамир, Эдийн засаг, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд профессор, доктор Л.Ганцэцэг, Японы Нагоя их сургуулийн профессор Китакора, Японы Шизүока муж Монголын хамтын ажиллагааны нийгэмлэгийн тэргүүн Катагава, Рио-2016 олимпийн их наадмын мөнгөн медальт Д.Сумъяа, хүрэл медальт Д.Отгондалай болон МУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирлууд болон эрдэмтэн багш, оюутан сурагчид, эцэг эхчүүдийн төлөөлөл хүрэлцэн ирсэн байлаа. Уламжлал ёсоор морин хуурын эгшиг аялгуугаар эрдмийн өргөөнийхөө жаврыг үргээж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын ажиллагааг МУБИС-ийн захирал, доктор профессор Д.Мөнхжаргал албан ёсоор нээлээ.

### Д.Мөнхжаргал: Чадварлаг багш нарыг бэлтгэхийн төлөө манай хамт олон зүтгэж байна

*/МУБИС-ийн захирал, доктор профессор/*

-Есдүгээр сарын 01-ний энэ сайхан өдөр МУБИС-ийн 2016-2017 оны шинэ хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагаанд УИХ-ын дарга М.Энхболд, БСШУС-ын сайд Ж.Батсуурь нар бидний урилгыг хүлээн авч, хүрэлцэн ирсэнд бид бүхэн баяртай байна. Энэ жил МУБИС-ийн 65 жилийн ой тохиож байгаа. Манай сургууль түүхэндээ 70 гаруй мянган мэргэжилтэн, багш нарыг бэлтгэн гаргасан, эрдмийн их уурхай, алдар түүхтэй сургууль юм. Бид бүхэн энэ сарын 30-нд түүхт ойгоо тэмдэглэх бөгөөд энд хуран цугласан та бүхэндээ 65 жилийн түүхт ойн баярын мэндийг дахин дэвшүүлье. Энэ хичээлийн жилд МУБИС-д 3000 оюутан шинээр элсч байна. Манай эрдмийн их уурхайд шинээр орж ирж буй оюутнууддаа халуун баяр хүргэж, сурлагын өндөр амжилт хүсье. МУБИС монгол хүнийг төлөвшүүлэх, Монголын багш нарыг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн, эх орноо гэсэн сэтгэлтэй, эв эеийг хичээдэг, эрдэм боловсролтой хүмүүсийг бэлтгэн гаргахын төлөө зорилт тавин ажиллаж байгаа. Бид багш бэлтгэх шинэ хөтөлбөр, стандартуудыг энэ хичээлийн жилд хэрэгжүүлж эхэлнэ. Багшийн чанарыг сайжруулах, эрс дээшлүүлэх тал дээр ч нэлээд дорвитой ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Орчин үеийн боловсрол судлал, сурган, сэтгэл судлалын арга зүй, технологи, арга ухааныг эзэмшсэн эрдэм бэлгэтэй, чадварлаг багш нарыг бэлтгэхийн төлөө манай хамт олон зүтгэж байна. Мөн энэ хичээлийн жилд “Оюутан төв”-тэй үйл ажиллагаануудыг нэлээд эрчимжүүлнэ. Түүнчлэн өнгөрсөн жил МУБИС-ийн харьяа лицей сургуулиа нээж байсан бол энэ жил харьяа цэцэрлэгээ нээж, эрдмийн уурхайгаа өргөжүүлээд байна. Манай сургууль сургуулийн өмнөх боловсролоос эхлээд эрдэмтэн, профессоруудыг бэлтгэх өргөн бүрэлдэхүүнтэй хамт олон болсон. Дашрамд дурьдахад, энэ хичээлийн жилтэй Олимпийн жил давхацсан. Манай сургуулийн хоёрдугаар курсын оюутан Д.Сумъяа маань жүдогийн спортоор олимпийн мөнгөн медаль хүртсэн амжилттай өнөөдөр хүрэлцэн ирлээ. Түүнчлэн Олимпийн хүрэл медальт Д.Отгондалай энэ жил манай сургуульд элсэн орж байна. Олимпийн хоёр медальтан манай сургуульд суралцахаар болсонд баяр хүргэж байна. Ингээд 2016-2017 оны шинэ хичээлийн жилдээ энд хүрэлцэн ирсэн нийт оюутан залуус, багш нартаа ажил хөдөлмөрийн болоод сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Харин УИХ-ын дарга М.Энхболд тус сургуулийн шинэ хичээлийн жилийн нээлтийн ажиллагаанд хэлсэн үгэндээ “Эрхэм хүндэт эрдэмтэн багш нар, оюутан залуустаа энэ өдрийн мэнд хүргэхийн зэрэгцээ Монгол Улсын өнцөг булан бүрт хичээлийн шинэ жилийнхээ нээлтийг хийж буй их дээд сургууль, МСҮТ-ийн оюутнуудад хичээлийн шинэ жилийн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье. Их, дээд сургуульд суралцах эрхийг олж авна гэдэг бол том хувь тавилан. Дээд боловсрол эзэмшиж, эрдэм боловсролоороо тэгш, хүмүүжлээрээ бусдад үлгэр дуурайлал болж чадахуйц, мэргэжилтэй боловсон хүчин болж улс эх орныхоо хойч ирээдүйг жолоодож явна гэдэг бол маш том хувь тавилан юм. Энэ хувь тавиланг хүүхэд залуучууд та бүхэн эдлэхдээ аль болох өөрийнхөө сонгосон мэргэжил, элсч орсон сургууль мэргэжлийнхээ онцлог зэрэг бүх зүйлийг зөвхөн багш нарын зааж, сургасан программын хүрээнд биш өөрийн эзэмшиж буй мэргэжил боловсролын чиглэлээр улс орны болоод тив дэлхийн хэмжээнд ямар шинэ зүйлүүд бий болж байна вэ гэдгийг эрэн хайж, сурч мэдэж өндөр төвшний боловсон хүчин болоорой гэдгийг юуны өмнө захимаар байна. Улс орны хөгжил бол хойч ирээдүй болсон хүүхэд, залуучуудын мэдлэг боловсролоос ихээхэн шалтгаалах нь ойлгомжтой. Тийм учраас хүүхэд багачууд хэр зэрэг чанартай сайн багш нараар эрдэм номоо заалгаж, сайн хүн хүмүүжинэ тэр хэмжээгээр улсын хөгжилд хувь нэмрээ оруулах хүн болж төлөвшинө гэсэн үг. Улс орны хойч ирээдүй ямар байхаас та бүхний энэ мэргэжлийг хэр эзэмшсэн нь хэмжигдэнэ. Би өнөөдөр хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлэг тэмдэг болсон Олимпийн их наадмын медальтнуудыг төрүүлсэн хамт олон, МУБИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцож байгаадаа баяртай байна. Та бүхэн сургуулийнхаа ойг сурлага, хөдөлмөр, хүмүүжил, урлаг спортын өндөр их амжилтаар угтахын ерөөлийг дэвшүүлье” хэмээсэн юм. Түүнчлэн “Монгол Улсын Засгийн газар дөрвөн жилийн хугацаанд улс орныг хөгжүүлэх, бүхий л салбарт хийж хэрэгжүүлэх ажлынхаа талаархи мөрийн хөтөлбөрийг боловсруулж, УИХ-д өргөн барьж, бид хэлэлцэж байна. Яг өнөөдөр хэлэлцэгдэж буй 2016 оны төсвийн тодотголд оюутан залуучууд төдийгүй эцэг эхийн тань сэтгэлийг зовоож байдаг сургалтын төлбөртэй холбогдсон асуудал орсон байгаа. Боловсролын санг шинэчлэн зохион байгуулж, энэ сангаас сургалтын төлбөрийн зээл олгодог, сургуулиа төгсөөд зээлээ эргүүлэн төлдөг тогтолцооны эхлэлийг тавьж, улсын төсөвт тодорхой хэмжээний хөрөнгийг тусгаж, энэ төсвийн тодотгол батлагдсаны дараа шууд хэрэгжиж эхэлнэ. Мөн оюутан залуучууд хөдөлмөр эрхэлж, сурахын хажуугаар ажил амьдралын дадлага сууж, ахуй амьдралдаа хэрэгцээтэй байгаа санхүү, хөрөнгөө шийдэхэд нь тус нэмэр болох зорилгоор ирэх дөрвөн жилийн хугацаанд “Орлоготой оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнээс гадна дотуур байрны хүрэлцээ хангамжийг сайжруулах, эрүүл мэндийн






үйлчилгээг харьялал харгалзахгүй авдаг болох зэрэг та нарын өмнө тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрийг Засгийн газар өргөн барьсныг дуулгахад таатай байна” гэсэн юм.

Ийнхүү хичээлийн шинэ жилийн ёслолын ажиллагаа МУБИС-ийн тугийг хүндэтгэн залах ёслолоор үргэлжлэв. Хүндэтгэлийн туг залах үүргийг Рио-2016 олимпийн их наадмын мөнгөн медальт Д.Сумъяа, хүрэл медальт Д.Отгондалай болон Таеквондогийн олон улсын хэмжээний мастер Э.Бүрэншагай, Спортын мастер Х.Сугаржав нар хүлээсэн юм. Туг залах ёслолын дараа 2016-2017 оны хичээлийн жилд шинээр оюутан болж буй элсэгчид тангараг өргөж, оюутан залуус МУБИС-ийн сүлд дуу “Үлэмж төгөлдөр”-ийг дуулж, эгшигэн цэнхэр хадаг өргөлөө. Хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр онцлох нэгэн үйл явдал болсон нь МУБИС-ийн 2013 оноос эхлэн ЭЕШ-д өндөр оноо авч, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад олгодог болсон тэтгэлгийг гардуулах агшин байлаа. Тодруулбал, 650-749 оноотой оюутанд сургалтын төлбөрийн 70 хувийг Сургалтын төрийн сангаас өндөр онооны тэтгэлэг болгон олгодог бол 750-иас дээш оноо авсан элсэгчид сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлгийг олгодог ажээ. Энэ хичээлийн жилд элсэгчдээс 70 хувийн тэтгэлэгт 509, 100 хувийн тэтгэлэгт 52 оюутан хамрагдах эрхтэй болсон байна. Мөн МУБИС-иас багш болох хүсэлтэй эрэгтэй оюутныг дэмжих зорилгоор Байгалийн ухаан, Математикийн хөтөлбөрөөр элсэгчдээс 600-аас дээш оноотой, Бага ангийн багш болон СӨБ, Хөгжмийн боловсролын хөтөлбөрөөр элсэгчдээс 550-иас дээш оноотой эрэгтэй оюутнуудад эхний жилийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгож эхэлжээ. Ийнхүү 50, 70, 100 хувийн тэтгэлэгт хамрагдсан оюутнуудад батламж гардуулах ажиллагаа эхэлсэн юм. Батламжийн салхийг Рио-2016 олимпийн их наадмын мөнгөн медальт Д.Сумъяа, хүрэл медальт Д.Отгондалай нар хагалж, 100 хувийн тэтгэлгийн батламжаа гардан авлаа. Энэ үеэр МУБИС-ийн Урлаг, Биеийн тамирын сургуульд элсэн орж буй ОУ-ын хэмжээний мастер, Олимпийн хүрэл медальт Д.Отгондалайн сэтгэгдлийг хуваалцлаа. Тэрбээр “Тамирчин хүнд тэр бүр сурах боломж ховор байдаг. Харин МУБИС-иас 100 хувийн тэтгэлэгт хамруулж, суралцах эрх өгч, боомж бололцоог бүрдүүлж өглөө. Мэдээж хэрэг спортын хүн учраас энэ чиглэлээрээ л суралцана. Сэтгэгдэл маш өндөр байна. Олимпийн наадам дуусаад нэлээд хугацаа өнгөрлөө. Удахгүй бэлтгэлдээ ороод 2017 оны ДАШТ-дээ бэлдэнэ. Хамгийн ойрын зорилго ДАШТ байна даа. Ингээд оюутан залуус та бүхэндээ хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе” хэмээсэн юм. Харин МУГТ, Олимпийн мөнгөн медальт Д.Сумъяа “Маш их баяртай байна. Миний хувьд МУБИС-ийн Урлаг, Биеийн тамирын сургуульд сурдаг. Энэ жил хоёрдугаар курст орж байна. Ингээд сургуулийнхаа нийт хамт олон, эрдэмтэн багш, оюутан залуустаа сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе” хэмээсэн. Ийнхүү 65 жилийн түүхтэй МУБИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлт ёслол төгөлдөр болж, өндөрлөлөө.

# УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# Г.Эрдэнэбат:

## ДАГАЛДАХ ХУУЛИУДЫГ БАТЛААГҮЙ ЦАГТ ЭРҮҮ БОЛОН ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ ХЭРЭГЖИХ ЯМАР Ч БОЛОМЖГҮЙ

Ж.ОТГОН

*Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль 2016 оны есдүгээр сарын 01 буюу өчигдрөөс эхлэн хэрэгжих байсан билээ. Гэвч хэд хэдэн шалтгааны улмаас хэрэгжүүлэх боломжгүй болж, хугацааг нь хойшлуулаад байгаа. Харин нийгэмд эдгээр хуулийн дагалдах хуулиудыг батлалсангүй, хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангалтгүй, Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор буюу улс төрийн шалтгаанаар хойшлуулсан гэх зэргээр олон янзаар тайлбарлаж байгаа. Тиймээс энэ талаар Улсын ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбаттай ярилцлаа.*



**-УИХ-ын чуулганы хуралдаанаар Засгийн газрын өргөн мэдүүлсэн Эрүүгийн болон Зөрчлийн гээд таван хуулийг буцаах тухай асуудлыг хэлэлцээд, баталчихлаа. Үүнд та ямар байр суурьтай байгаа вэ?**

-Эрүүгийн болон Зөрчлийн хууль бол батлагдчихсан, хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа нь өнөөдөр буюу есдүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх байсан. Гэхдээ УИХ-аас хууль батлагдаж, 2017 оны долдугаар сарын 01-ний өдрөөс эхлээд үйлчилж эхлэх юм шиг байна. Хуулийн хэрэгжилт талаас нь аваад үзэхээр хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөх гурван дэг журам байдаг. Нэгдүгээрт, хууль батлагдсан өдрөөсөө эхлээд хүчин төгөлдөр болдог. Хоёрдугаарт, тухайн хууль хүчин төгөлдөр болох хугацааг заадаг. Гуравдугаарт, хүчин төгөлдөр болох хугацааг тогтоосон өөр хуулийг гаргадаг. Харин Эрүүгийн буюу Зөрчлийн хуулийн хувьд хүчин төгөлдөр болох хугацааг нь заагаад өгчихсөн. Гэтэл одоо хүчин төгөлдөр хугацааг өөрчилсөн хууль гарч байх шиг байна.

**-Тэгвэл хуульчид өнөөдөр үйлдэгдсэн хэргийг хуучин хуулиараа шийдвэрлэж байгаа гэсэн үг үү?**

-Нэг зовлонтой асуудал нь одоогийн байдлаар хуульчид бидний гар дээр Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг хэзээ гэдгийг тогтоосон хууль хэвлэгдэж гарч ирээгүй байна. Албан ёсоор хууль батлагдаад, “Төрийн мэдээллийн эмхэтгэл” сэтгүүл дээр хэвлэгдсэнээс хойш 10 хоногт хүчин төгөлдөр болж үйлчлэхээр Үндсэн хуульд заасан байдаг. Тэгвэл одоо ямар асуудал үүсээд байна вэ гэхээр есдүгээр сарын 01 гээд Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн үйлчлэх хугацаа тоологдоод эхэлчихлээ. Харин уг хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг хойшлуулсан хууль маань хэвлэгдэж гарч ирээгүй байгаа. Тиймээс өнөөдөр үйлдэгдсэн хэргийг аль хуулиар нь шийдэх эсэх дээр ойлгомжгүй нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

**-Энэхүү ойлгомжгүй байдлыг шүүгчид хэрхэн зохицуулж байгаа бол?**

-Батлагдсан хууль маань яаж хэвлэгдэж гарах нь вэ. Есдүгээр сарын 01-нээс хойш үйлдэгдсэн хэргийг өмнөх хуулиар нь шийдвэрлэх талаар шүүхийн практик тогтоох шаардлагатай болох байх даа. Түүнээс ойлгомжгүй байна гээд хууль хэрэгжүүлэх ажил зогсох ёсгүй. Үүнийг нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй.

**-Ийнхүү Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулж байгааг улс төртэй холбон тайлбарлах хүн олон байна. Тэгвэл яг одоо эдгээр хууль үнэхээр хэрэгжиж эхлэхэд бэлэн бус байгаа юм уу, эсвэл?**

-Энэ хуулийг хэн хэрэгжүүлэх, ямар журмаар ажиллах, зөрчил гаргасан хүнтэй хариуцлага тооцох байцаагч ямар эрх мэдэлтэй байх, ямар эрх зүйн орчин дотор ажиллах, хүний эд хөрөнгийг хураахдаа, эрх чөлөөг нь хязгаарлахдаа ямар дэг журмаар ажиллах юм гэдэг эрх зүйн орчин бүрдэх ёстой. Тэгэхээр Зөрчлийн тухай хууль 2017 оны долдугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ гэж тавихдаа биш, дагалдах хуулиудыг батлаагүй учир угаасаа Эрүүгийн болон Зөрчлийн хууль хэрэгжих ямар ч боломжгүй. Тэдгээр хуулиудыг хамтад нь нэг цаг хугацаанд хэрэгжүүлэх ёстой. Тиймээс Засгийн газар нэгэнт хуулийг буцаасан бол дүрмээрээ Эрүүгийн болон Зөрчлийн хууль есдүгээр сарын 01-нээс хэрэгжих ямар ч боломжгүй. Учир нь Эрүүгийн болон Зөрчлийн хууль маань асуудлыг шийдвэрлэх шинэ дүрэм, журам, шинэ эрх зүйн үзэл санаа тогтоочихсон учир түүнийг хэрхэн яаж гэдгийг зохицуулсан тухай хуулиуд байхгүйгээр хэрэгжих боломжгүй.

**-Зөрчлийн хууль гэхээр өмнө нь огт байгаагүй цоо шинэ хууль гараад ирлээ гэж ойлгох хүн цөөнгүй байх шиг байна. Энэ хууль өмнө нь яаж хэрэгжиж ирсэн байдаг вэ?**

-УИХ-аас Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Энэ хоёр хууль өмнө нь Монгол Улсад байсан эрх зүйн хэм хэмжээг шинэчилж хөгжүүлсэн хэрэг юм. Эрүүгийн хуулийг дагасан олон өөрчлөлт, шинэчлэлтүүд орсон. Мөн Эрүүгийн хуультай зайлшгүй хамт яригдах ёстой Зөрчлийн хууль нь хариуцлагын тогтолцоог шинээр төрөлжүүлэн нэгтгэх эрх зүйн хууль тогтоомжийн шинэчлэлийн ажил хийгдсэн. Энэ хуулийн суурь өмнө нь Монгол Улсад огт байгаагүй зүйл биш, байсан. Аль 1993 оноос эхэлж үйлчилж байсан Захиргааны хариуцлагын хууль маань шинэ найруулгаар буюу шинэчилсэн найруулгатайгаар батлагдаад явж байгаа. Энэхүү Зөрчлийн тухай хууль бол Монгол Улсад нийтдээ 224 хуулийн ард тус тусдаа салангид байдлаар хуульчилсан байсан хариуцлагуудыг төрөлжүүлж, нэгтгэсэн асуудал юм.

**-Зөрчлүүдийг төрөлжүүлэн тусдаа хууль болгон нэгтгэх нь ямар ач холбогдолтой юм бэ. Тэртэй тэргүй хуулиудын ард салангид байдлаараа байсан зүйлийг?**

-Нэгтгэхийн ач холбогдол нь ямар учиртай юм бэ гэхээр Монгол Улс олон төрлийн хуулийн хариуцлагын стандарттай болчихсон байсан. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хууль дээр нэг төрлийн зөрчилд хариуцлага хүлээлгэж байхад түүнтэй нэлээд ойролцоо төрлийн зөрчлийг Ойн тухай хуулиар, өөр нэг ойролцоо төрлийн зөрчлийг Байгаль орчны хамгаалах тухай хуулиар гэх мэтээр олон хууль тогтоомжийн стандарт байдаг. Эдгээр зэрэгцээ стандартаас болоод ямар асуудал үүссэн бэ гэхээр хуулийн давхардал гэдэг зүйл бий болж эхэлсэн. Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, өөр хариуцлага тогтоосон хуулиуд гээд хоорондоо давхардах хууль маш олон гарсан. Нийтдээ 34 гэмт хэрэг, 40 гаруй зөрчил хоорондоо давхацсан байдалтай байсан. Тиймээс эдгээр давхардлыг арилгаж, зохицуулж өгсөн.

**-Хуулийн давхардал үнэхээр их гардаг байж. Тэгвэл хууль сахиулж байгаа хүмүүс аль хуулийг нь барьж тухайн хүнд хариуцлага тооцох нь дурын асуудал байдаг хэрэг үү?**

-Аль хуулийг барьж хариуцлага хүлээлгэх вэ гэдэг асуудал дээр ойлгомжгүй байдал үүсэх нь үүснэ. Ганцхан жишээ хэлэхэд, Монгол Улсын Эрүүгийн хуульд баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт хуурамчаар үйлдэх нь гэмт хэрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, эх болгосон баримт бичиг хуурамчаар үйлдсэн бол тухайн хүнд Эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гээд заачихсан байдаг. Гэтэл манай Боловсролын тухай хуулийн хариуцлагын хэсэгт боловсролын баримт бичгийг хуурамчаар үйлдэж, ашигласан бол Захиргааны хариуцлага хүлээлгэхээр заачихсан байгаа. Энэ нөхцөл байдлаас практикт ямар нөхцөл байдал үүссэн бэ гэхээр дээд боловсролын диплом ашиглаад ажилд орчихсон хүнийг боловсролын хяналтын улсын байцаагч илрүүлчихээд, Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үү, Захиргааны хариуцлага хүлээлгэх үү гэдэг нь ойлгомжгүй болж ирэх жишээтэй. Ийм олон хийдэл, давхардал хууль тогтоомжийн системгүй байдлаас болоод олон асуудал, бэрхшээлүүд үүсч байсан. Тиймээс бид энэ хуулиудыг төрөлжүүлэн нэгтгэж, эмхэтгэх хэрэгтэй юм байна гэж үзсэн. Нэг стандарттай хариуцлагын ижил хэмжээтэй, шийтгэлийн нэг бодлоготой зөрчил гаргасан хүнд хариуцлага хүлээлгэдэг албан тушаалтан нь тодорхой, хариуцлага хүлээлгэдэг шийтгэлийн төрөл хэмжээ нь тодорхой, хариуцлага хүлээлгэдэг зөрчлийнх нь бүрэлдэхүүн шалгуур нь тодорхой байх ёстой гэж үзээд хуулийг төрөлжүүлэн нэгтгээд Зөрчлийн тухай хууль гаргасан. Одоо бол Эрүүгийн хуульд байдаг зарчмын дагуу аливаа эрүүгийн хэргийг шалгаж, шийдвэрлэхэд эргэлзээ төрөх, хуулийг тайлбарлахад тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд буруутгагдаж байгаа хүндээ ашигтайгаар шийдвэрлэдэг зарчмаар л явж байгаа. Өөрөөр хэлбэл, давхцал үүссэн хоёр хууль байхад буруутгагдаж байгаа хүнд нь аль хөнгөн тусах хуулиар нь шийддэг практик тогтчихсон явж байгаа.

**-Хэрвээ Зөрчлийн хууль хэрэгжээд эхэлбэл манай улс хуулийн хариуцлагыг тал дээр том алхам болно гэж үзэж байгаа. Үнэхээр нийгэмд байдаг олон хариуцлагагүй байдлыг таслан зогсоож чадах болов уу?**

-Энэ дөнгөж сая хийгдчихсэн ажил биш. Захиргааны хариуцлагын тухай хуулийг төрөлжүүлэн нэгтгэх ажил миний ойлгож байгаагаар 2008 оноос хойш хийгдсээр ирсэн байдаг. Тэр нь явсаар байгаад өнөөдөр Зөрчлийн тухай хууль хэмээн шинэчилсэн найруулгатай хууль гарсан. Энэ хууль үйлчилж эхэлснээр манай нийгэмд үүсээд байгаа олон хариуцлагагүй байдлыг таслан зогсоох болно. Нийгмийн хууль зүйн хариуцлагыг цэгцтэй болгоход их тустай хууль юм. Ний нуугүй хэлэхэд, Монгол Улс хариуцлагын тал дээр их ядмаг болчихсон байсан. Тухайлбал, ямар нэгэн ноцтой гэмт хэрэг гарахаар хүмүүс ямар аюултай гэмт хэрэг гарчихав аа, энэ яагаад ийм болов гээд л тэр үйлдлийг жигшиж, буруу үйлдлийг хатуу шийтгэж, цээрлүүлэхийг шаардаж эхэлдэг. Хуулийн байгууллага ч гэнэт л ноцтой гэмт хэрэгтэнтэй тулаад эхэлдэг юм. Гэтэл тухайн гэмт хэргийн суурь дандаа ялимгүй жижиг зөрчлүүдээс эхэлсэн байдаг. Тэр зөрчлийг бид удаан хугацаанд тоохгүй явсаар байгаад, нөгөөх нь даамжирч ноцтой гэмт хэрэг болдог. Энэ бол өөрөө гэмт хэргийн үүсдэг зүй тогтол нь юм. Гэмт хэргийн үүсэл ч гэж хэлж болно. Тухайлбал, бид модны жижиг хулгайг тоодоггүй. Нэг хүн зөвшөөрөлгүй мод бэлтгэж байхад хэн ч асуудал болгоод байдаггүй. Тэнд нэг эрх мэдэл, хүч нөлөө муутай байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч л багахан хэмжээний төгрөгөөр торгоод л яваад байдаг. Хэчнээн газар хууль бусаар мод бэлтгээд байгааг бүртгэдэггүй, хэчнээн хүнд хариуцлага тооцсон гэдгийг шалгадаггүй. Тиймээс зөрчил бүрт нь хариуцлага тооцож байна гэдгийг бид мэдэрдэггүй явсаар л байна. Харин нөгөө мод бэлтгэдэг хүн маань энэ бизнес ашигтай юм байна гэдгийг мэдээд, амтанд нь ороод ирэхээрээ аажимдаа зохион байгуулалтад ордог. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн түвшинд өндөр зохион байгуулалттайгаар хуулийн байгууллагатай чоно, туулай болж хөөцөлдөж явсаар мод бэлтгэдэг гэмт хэрэг болохоор нь сая бид тэдэнтэй ширүүн тэмцэхийг шаарддаг. Түүнчлэн ялимгүй жижиг гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн маргаан буюу “эр эмийн хооронд илжиг бүү жороол” гэдэг үгээр хаацайлж, тоохгүй хаядаг. Ийнхүү явсаар, өнөөх нь даамжирсаар хүн амины ноцтой гэмт хэрэг болохоор нь яагаад хүүхдээ алчихав аа, яагаад эхнэрээ хөнөөчихөв гэж жигшээд байдаг. Тэгвэл ингэж болохгүй. Хэрвээ бид нийгмийн тогтолцоогоо хариуцлагатай байлгая гэвэл ноцтой гэмт хэрэг гарахаас нь өмнө таслан зогсоодог байх ёстой. Тэгвэл энэ асуудалд Зөрчлийн тухай хууль онцгой үүрэгтэй. Ийм нэгдсэн хариуцлагын тогтолцоотой байж гэмээнэ хуулийн байгууллага гэнэт аюултай, ноцтой гэмт хэрэгтэй тулах биш харин нийгэмд аюултай үзэгдлүүдийг бага дээр нь таслан зогсоож, зөрчил гаргасан хүмүүст тухай бүрт нь хариуцлага тооцож, буруу үйлдэл хийсэн гэдгийг нь ойлгуулах ёстой юм.

ХААЛТТАЙ ХУРАЛДААНААС

## Д.Хаянхярваа: Цалинг бууруулахгүй байх нэгдсэн шийдэлд хүрсэн

УИХ дахь МАН-ын бүлгийн өчигдрийн хуралдаанаар хэлэлцсэн "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөл болон төсвийн тодотголын асуудлаар бүлгийн дарга Д.Хаянхярваа, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нар мэдээлэл хийлээ. Бүлгийн хуралдаанаар төрийн албан хаагчдын цалинг бууруулахгүй байх нэгдсэн шийдэлд хүрсэн байна. Харин татвар нэмэх эсэх асуудлыг ажлын хэсэг дахин нягталж үзэхээр боллоо. Тухайлбал, онцгой албан татвар, 150 метр квадратаас дээш талбайтай орон сууц, автомашины хуучин эд анги оруулж ирдэг хувь хүн, аж ахуйн нэгж, цалингийн шаталбараас хамааралтай татварын асуудлыг дахин авч хэлэлцэхээр болсон байна. УИХ-ын ээлжит сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байна гэж бүлгийн гишүүд үзсэн байна. Энэ талаар бүлгийн дарга Д.Хаянхярваа “Бид төсвийн тодотголтой холбоотой асуудалд нэлээд анхаарал хандуулсан. Нийгэмд цалин хасах нь, татвар нэмэх нь, хүүхдийн мөнгө, оюутны тэтгэлгийг зогсоох нь гэсэн мэдээлэл түгж байна. УИХ-д өргөн барьсан төсөл хөтөлбөр эцсийн баримт биш. УИХ-аар өргөн барьсан төслийг баталж байж эцсийн шийдвэр гардаг. Өргөн барьсан төслийг эхлээд бүлэг, байнгын хороо, чуулганаар хэлэлцэж байж төсвийн тодотгол хууль болж эцсийн баримт бичиг болж гарна. Өнөөдрийн хуралд Засгийн газрын гишүүдийг байлцуулж байгаад эдийн засгийн нөхцөл боломжийн талаар ярилцлаа. Үндсэндээ Засгийн газрын оруулж ирж байгаа мөрийн хөтөлбөрийн хүрээнд авч үзэхэд эдийн засаг бидний тооцоолж байснаас харьцангүй доогуур нөхцөл байдалтай байна. Тиймээс Засгийн газрын оруулж ирж буй мөрийн хөтөлбөр бол өнөөгийн эдийн засгийн чадамжид тулгуурласан гэж ойлгох хэрэгтэй” гэв. Засгийн газраас хүүхдийн мөнгийг зорилтот бүлгийн 60 хувьд олгож, 40 хувьд нь 2-3 жилийн дараа боломжит хувилбараар өгөх, Оюутны тэтгэлгийн санг 90 тэрбум төгрөгөөр байгуулах санал оруулж ирснийг МАН-ын бүлэг дахин судлах шаардлагатай гэж үзсэн байна. МАН-ын бүлэг өнөөдөр дахин хуралдаж, энэ талаарх шийдвэрээ эцэслэн гаргах юм байна.


АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА



Зах зээлдээ тэргүүлэгч худалдааны компанид дараах ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж байна.

-МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

Ажлын байрны зорилго:

Компанийн реклам сурталчилгаа, олон нийтийн харилцааны бодлогын хүрээнд харилцагчид, зах зээл, хэрэглэгчидэд чиглэсэн бүх төрлийн реклам сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах, үр нөлөөг нь үнэлэх, дүгнэх, борлуулалтыг нэмэгдүүлэх

Тавигдах шаардлага:

- ✓Маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- ✓Баримт бичиг боловсруулах, тооцоо судалгаа хийж, дүгнэлт өгөх чадвартай
- ✓Илтгэх, танилцуулах, олон нийттэй харилцах өндөр ур чадвартай
- ✓Удирдан зохион байгуулах, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй
- ✓Хувийн зохион байгуулалт сайтай
- ✓Багаар ажиллах чадвар сайтай

Бүрдүүлэх материал:

- ✓CV буюу өөрийн танилцуулга
- ✓Бакалавр болон магистрын дипломны хуулбар
- ✓Цахим үнэмлэхний хуулбар
- ✓Сүүлийн 3 сард авахуулсан өнгөт 3x4 цээж зураг 1%

Холбоо барих: 9595-0095

Материал хүлээн авах хаяг: Erinbileg1@gmail.com

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2016.09.11

# ДЭЛХИЙ



## "Цөс ихтэй" ГАБОНЧУУД төрийн ордоноо шатаав

Б.ДАВАА

Төв африкт орших 1.5 сая хүн амтай Бүгд найрамдах Габон улсын Ерөнхийлөгчийн бүх нийтийн сонгууль өнгөрсөн долоо хоногийн сүүлчээр зохион байгуулагдсан юм. Гэвч сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн "цөс ихтэй" габончууд төрийн ордондоо гал тавьж, эмх замбараагүй байдал үүсгэжээ. Энэ удаагийн сонгуулиар тус улсын Ерөнхийлөгч Али Бонго Ондимба улиран сонгогдсон нь ийнхүү бослого хөдөлгөөнд хүргэсэн байна.

1961 оноос хойш тусгаар тогтнолоо олсон энэ улсад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа долоон жил байдаг ч, 2003 онд Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгогдох хязгаарыг арилгахаар өөрчлөлт оруулсан удаатай. Ерөнхийдөө тусгаар улс болсноосоо хойш ердөө хоёр л Ерөнхийлөгчийн нүүрийг үзэж буй ажээ. 1990-ээд оны эхэнд Габон олон намын тогтолцоо нэвтрүүлж, сонгуулийн ажиллагааг ил тод болгож, төрийн байгууллыг шинэчилсэн шинэ ардчилсан үндсэн хуультай болсон юм. Тэгвэл энэ улсад өнгөрөгч бямба гарагт Ерөнхийлөгчийн сонгууль явагдаж, өнөөгийн Ерөнхийлөгч нийт сонгогчдын 49.80 хувийн дэмжлэгийг авч, улиран сонгогдсон байна. Гэвч Сонгуулийн Ерөнхий хорооноос дүнг нийтэд зарласны дараа зарим хүмүүс нийслэл Либревилль хотноо бослого дэгдээж, парламентын ордоныг галджээ.

Эмх замбараагүй байдал өчигдөр ч үргэлжилсэн байна. Сөрөг хүчнийхний ийн балмад аашилсны дараа Засгийн газар ч зүгээр суусангүй. Тус улсын Аюулгүйн албаныхан гэмт хэрэгтнүүдийг барихын тулд сөрөг хүчний төв байр руу халдаж, томоохон хэмжээний мөргөлдөөн үүсгэжээ. Энэ үеэр хоёр хүн нас барж, 19 хүн гэмтэж бэртсэн байна. Сонгуульд сөрөг хүчнээс Африкийн холбооны экс дарга Жан Пин нэр дэвшсэн бөгөөд тэрбээр 48.23 хувийн санал авч, маш бага зөрүүтэйгээр ялагдал хүлээсэн юм. Гэвч одоогийн Ерөнхийлөгчийнхөө эрх мэдлийг дахин үргэлжлүүлэхийг хүсээгүй габончууд Ерөнхийлөгч Али Бонго Ондимбаг хууль зөрчин сонгуулийг луйвардсан хэмээн үзэж буй аж. Тэд аюулгүйн албаныхантай мөргөлдсөний дараа зургаа нь гэмтжээ.

Үүнээс гадна Либревилль хотын хэд хэдэн хэсэгт буун дуу гарч, парламентын ордон бүхэлдээ шатаж байсныг орон нутгийн гэрчүүд хэвлэлд мэдээлжээ. Сөрөг хүчнээс Ерөнхийлөгчид нэр дэвшсэн Жан Пиний ярьж буйгаар мөргөлдөөн өчигдөр 01.00 цагийн үед болжээ. Харин зарим эх сурвалжийн мэдээлснээр "Засгийн газрынхан нисдэг тэргээр сөрөг хүчний төв байр руу агаараас цохилт өгсний дараа хэд хэдэн газраас гал нээж, 19 хүн гэмтэж бэртсэн" гэнэ. Тухайн үед Пин намын байрандаа байгаагүй аж. Харин яг тэр үед барилга дотор байсан сөрөг хүчний гишүүн Зачари Мибото аюулгүйн албаныхан эхлээд барилга руу нулимс асгаруулагч хий тавьж, дараа нь буудаж эхэлснийг гэрчилсэн байна. Нөгөөтэйгүүр, Засгийн газрын хэвлэлийн албанаас ч гэсэн хариу тайлбар хийгээд байгаа юм. Тэдний мэдэгдсэнээр сөрөг хүчний төв байр руу цагдаагийнхан төрийн ордоныг галдсан гэмт хэрэгтнүүдийг баривчлах зорилгоор довтолсон гэнэ. "Ордонд гал тавьсан хүмүүсийн дунд Жан Пин өөрөө байсан. Олон зуун дээрэмчин, тонуулчидтайгаа хамт байсан. Тэд улстөрийн зорилготой жагсагчид биш гэмт хэрэгтнүүд" хэмээн Засгийн газрын хэвлэлийн албанаас албан ёсны тайлбар өгчээ.



## Трампын нүцгэн баримлыг худалдана

АНУ-ын Калифорни мужийн Беверли Хиллст байрлах "Julien's Auction" компани тус улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшиж буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампын нүцгэн баримлыг үнэ хаялцуулан худалдахаар болжээ. Эрс ширүүн мэдэгдлээсээ болж шүүмжлэлд өртөх нь олонтаа Доналд Трампын эсрэг сурталчилгааны нэг хэлбэр болох уг нүцгэн баримал АНУ-ын томоохон хотуудаар тойрсон юм. Харин ирэх сарын 22-нд хамгийн өндөр үнэ хэлсэн эрхмийн гарт уг баримал очихоор болсон аж. Зохион байгуулагчдын тооцож буйгаар "Нүцгэн Трамп" 10-20 мянган ам.долларын үнэ хүрэх гэнэ. Энэ бүтээлийг Калифорнийн ашгийн бус "Indecline" компани бүтээсэн бөгөөд наймдугаар сарын 18-нд Холливудын өргөн чөлөөнд байрлаж байв. Том гэдэстэй гараа цээжиндээ авсан байдалтайгаар бүтээгдсэн баримал "Зориг, зүрхгүй хаан" гэх үгийг сийлжээ. Баримал өмнө нь Нью-Йорк, Сийтл гэх мэт дөрвөн хотоор тойрч, олны анхаарлыг ихээр татсан билээ. Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болсон тохиолдолд хууль бусаар оршин суух 11 сая хүнийг хүчээр нутаг буцаана хэмээн амласан нь олон хүний эгдүүцлийг төрүүлсэн. Тэгвэл дуудлага худалдаанаас олсон орлогын зарим хэсгийг цагаачдад чиглэсэн үйл ажиллагаа явуулах "Үндэсний цагаачдын форум" гэх байгууллагад хандивлахаар болжээ.

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Доорх жагсаалтад нэр дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Та бүхэн хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж бүртгүүлэхийг мэдэгдье.

| № | Код | Эзэмшигч | Талбай (га) | Олгосон огноо |
|---|---|---|---|---|
| 1 | MV-010380 | Говьгео | 29,42 | 2005.09.01 |
| 2 | XV-011974 | Цэнбаялаг | 9717,58 | 2006.09.01 |
| 3 | XV-014088 | Мизү | 1601,03 | 2008.09.01 |
| 4 | XV-014089 | Мизү | 8586,12 | 2008.09.01 |
| 5 | XV-014084 | ДБТХ | 672,56 | 2008.09.01 |
| 6 | XV-018555 | СННС | 5488,36 | 2015.09.02 |
| 7 | MV-016982 | Хонгорын орд | 84,49 | 2002.09.02 |
| 8 | XV-014092 | Хадат өндрийн өгөөж | 159,11 | 2008.09.02 |
| 9 | XV-020586 | Эм Эн ЭМ | 936,93 | 2015.09.02 |
| 10 | MV-004822 | Алтандорнод монгол | 114,46 | 2002.09.02 |
| 11 | MV-019116 | Их мөрөн шинэ ван | 200,12 | 2015.09.03 |
| 12 | XV-015099 | Алтарганахайрхан | 14835,42 | 2009.09.03 |
| 13 | XV-017881 | Ресурс партнерс групп | 1798,08 | 2015.09.03 |
| 14 | MV-017378 | Гоулдсэнын монголиа | 199,29 | 2013.09.03 |
| 15 | XV-018942 | Талын Монгол Групп | 13300,35 | 2015.09.03 |
| 16 | XV-018937 | Талын Монгол Групп | 839,14 | 2015.09.03 |
| 17 | MV-019137 | Монгол чадал интернэшнл энержи | 1110,49 | 2015.09.03 |
| 18 | XV-018527 | Хайландфорс | 18023,8 | 2015.09.03 |
| 19 | MV-004839 | Алтандорнод монгол | 55,89 | 2002.09.03 |
| 20 | XV-015112 | Жорчидай | 943,95 | 2009.09.04 |
| 21 | MV-011979 | Монгол-Анар трейд | 376,08 | 2006.09.04 |
| 22 | MV-011981 | Цагаан-Элгэн | 30,11 | 2006.09.04 |
| 23 | MV-012680 | Ёнченг | 6,17 | 2007.09.04 |
| 24 | XV-014108 | Топазстоне майнинг | 69950,73 | 2008.09.04 |
| 25 | XV-014105 | Сауд гоби блейк гоулд | 651,27 | 2008.09.04 |
| 26 | XV-015114 | Мочистоун | 1470,54 | 2009.09.04 |
| 27 | MV-017604 | Туншан шиандон | 42,12 | 2014.09.05 |
| 28 | XV-011990 | Монлаа | 4128,05 | 2006.09.05 |
| 29 | XV-011987 | Өгөөмөр-Алт | 2866,34 | 2006.09.05 |
| 30 | MV-011985 | Эс Эм Ай | 1229,15 | 2006.09.05 |
| 31 | MV-004852 | Спот констракшн | 29,43 | 2002.09.06 |
| 32 | XV-010407 | Принципал инвестмент | 1960,33 | 2005.09.06 |
| 33 | MV-017119 | Кеналхап | 97,02 | 2012.09.06 |
| 34 | XV-012685 | Алкалли метал монголиа | 12410,94 | 2007.09.06 |
| 35 | MV-017120 | Тайшэн девелопмент | 907,49 | 2012.09.06 |
| 36 | MV-015649 | Орчлон констракшн | 33,74 | 2010.09.07 |
| 37 | MV-019843 | Эй Эйч Жи металлс групп | 295,04 | 2011.09.07 |
| 38 | MV-017117 | Маркополо | 321,71 | 2012.09.07 |
| 39 | MV-017118 | Шинэ жес гранд уул уурхай | 450,56 | 2012.09.07 |
| 40 | MV-017430 | Эй Эйч Жи металлс групп | 713,12 | 2011.09.07 |
| 41 | MV-020415 | Гангархаш | 80,12 | 2007.09.07 |
| 42 | XV-018090 | Платинумланд | 2184,44 | 2015.09.08 |
| 43 | XV-018951 | Иххүдэр | 2696,7 | 2015.09.08 |
| 44 | MV-019149 | Энхтунх орчлон | 6664,61 | 2015.09.08 |
| 45 | MV-015651 | Оргил моунт | 1130,73 | 2010.09.08 |
| 46 | XV-018825 | Оюу-Орд | 5813,33 | 2015.09.08 |
| 47 | XV-018406 | Эм Би Би Си | 11216,36 | 2015.09.08 |
| 48 | MV-014112 | Чин | 277,54 | 2008.09.08 |
| 49 | XV-018921 | Эм Эл гоулд | 3833,14 | 2015.09.08 |
| 50 | MV-016653 | Улз гол | 657,97 | 2010.09.09 |
| 51 | MV-020417 | Минюу шиши | 97,24 | 2009.09.09 |
| 52 | MV-017027 | МГМК | 64,04 | 2008.09.09 |
| 53 | MV-019187 | Салхит майнинг | 1334,28 | 2015.09.09 |
| 54 | XV-014132 | Топазстоне майнинг | 5040,98 | 2008.09.09 |
| 55 | MV-012630 | Эрдэнэсмайнинг | 116,45 | 2007.08.10 |
| 56 | XV-017597 | Болоргол | 41,85 | 2008.09.09 |
| 57 | XV-014131 | Кожеговь | 26236,77 | 2008.09.09 |
| 58 | MV-015119 | Бужгар-Орд | 379,25 | 2009.09.09 |
| 59 | XV-014138 | Болоргол | 85,79 | 2008.09.09 |
| 60 | XV-014126 | Шинэлонгда | 9245,88 | 2008.09.09 |
| 61 | MV-015124 | Нэйчө | 523,64 | 2009.09.10 |
| 62 | XV-017016 | Дөрвөнхүмүүн | 962,06 | 2006.10.25 |
| 63 | XV-014145 | Элбэг-орд | 8397,73 | 2008.09.10 |
| 64 | XV-014148 | Ихтүмэн бээр | 39,55 | 2008.09.11 |
| 65 | XV-015132 | Пакимор | 3694,2 | 2009.09.11 |
| 66 | XV-014156 | Рэдхилмонголия | 7385,23 | 2008.09.11 |
| 67 | XV-015129 | Централ эйшиан цемент | 56,75 | 2009.09.11 |
| 68 | MV-012700 | Төгс-Эхлэл | 53,16 | 2007.09.11 |
| 69 | MV-017609 | Блэкпланет | 245,7 | 2014.09.11 |
| 70 | MV-017610 | Монсөнөд | 37,36 | 2014.09.11 |
| 71 | MV-019225 | Фэско | 53,85 | 2015.09.11 |
| 72 | XV-012702 | Афро азия минералз | 25640,31 | 2007.09.11 |
| 73 | XV-014152 | Дүүлэх шонхор | 8136,56 | 2008.09.11 |
| 74 | MV-014147 | Эрдэнэдорно | 228,81 | 2008.09.11 |
| 75 | XV-012692 | Говьхурах | 5441,31 | 2007.09.11 |
| 76 | MV-010423 | Жиншентан | 15,94 | 2005.09.12 |
| 77 | XV-012703 | Уэлт-Эксплорэйшн | 11906,85 | 2007.09.12 |
| 78 | XV-011999 | Нарлагбаян Алтай | 2282,8 | 2006.09.12 |
| 79 | XV-012707 | Тройгоби | 3663,2 | 2007.09.12 |
| 80 | XV-012704 | Трежур-Эксплорэйшн | 22476,22 | 2007.09.12 |
| 81 | MV-017131 | Монлаа | 585,55 | 2012.09.12 |
| 82 | XV-012705 | Империал метал групп | 22763,05 | 2007.09.12 |
| 83 | MV-004872 | Дорнын нүүрс | 81,49 | 2002.09.13 |
| 84 | XV-012712 | Урагшлахговь | 2100,55 | 2007.09.13 |
| 85 | MV-019233 | Мийдлгоби майнинг | 2910,51 | 2015.09.14 |
| 86 | MV-010434 | Монголруд пром | 41,7 | 2005.09.14 |
| 87 | MV-010431 | Алтандорнод монгол | 41,55 | 2005.09.14 |
| 88 | XV-010439 | Содгазар | 92,86 | 2005.09.14 |
| 89 | MV-017036 | Тэсийн хурд | 122,48 | 2005.09.14 |
| 90 | XV-018985 | Геоталст | 3096,19 | 2015.09.15 |
| 91 | XV-018980 | Цахирт өндөр майнинг | 4255,47 | 2015.09.15 |
| 92 | XV-014162 | Саруул сансар | 3771,56 | 2008.09.16 |
| 93 | MV-017384 | Эм Ди Эф И | 2057,36 | 2013.09.16 |
| 94 | XV-015140 | Эмэмарай | 144,17 | 2009.09.16 |
| 95 | MV-016658 | Болоршүр | 345,46 | 2010.09.16 |
| 96 | MV-016657 | Монголросцветмет | 133,08 | 2010.09.16 |
| 97 | MV-004878 | Монголросцветмет | 66,47 | 2002.09.17 |
| 98 | MV-001865 | Үүрттур | 227,34 | 1999.09.17 |
| 99 | XV-006325 | Адамасмайнинг | 6262,92 | 2003.09.17 |
| 100 | XV-018418 | Стархолдинг | 6694,78 | 2015.09.18 |
| 101 | XV-012720 | Топазстоне майнинг | 162,7 | 2007.09.18 |
| 102 | MV-012721 | Алтайконстракшн | 72,29 | 2007.09.18 |
| 103 | XV-013400 | ЭБГ | 194,58 | 2007.09.18 |
| 104 | XV-016677 | Говьшоо | 100,42 | 2007.09.18 |
| 105 | MV-019328 | Түшээговь | 1967,96 | 2015.09.18 |
| 106 | XV-018391 | Цогш | 740,52 | 2015.09.18 |
| 107 | MV-017611 | Олгойбулаг | 470,82 | 2014.09.19 |
| 108 | XV-012028 | Цэвдэг | 610,25 | 2006.09.19 |
| 109 | MV-012039 | Бороогоулд | 910,57 | 2006.09.19 |
| 110 | MV-012031 | Ирвэс-интертрейд | 451 | 2006.09.19 |
| 111 | MV-012029 | Цэвдэг | 139,05 | 2006.09.19 |
| 112 | MV-010457 | Бриджконстракшн | 32,17 | 2005.09.19 |
| 113 | MV-017100 | Авдарбаян | 28,44 | 2002.09.19 |
| 114 | MV-017408 | Мондулаан трейд | 313,79 | 2006.09.19 |
| 115 | MV-010489 | Бат-Адар | 30,95 | 2005.09.20 |
| 116 | MV-010483 | Хунхуа | 24,31 | 2005.09.20 |
| 117 | MV-012726 | Саусгоби сэндс | 9282,76 | 2007.09.20 |
| 118 | MV-017035 | Тэсийн хурд | 25,33 | 2007.09.20 |
| 119 | XV-010484 | Хонгорхангай эрдэнэс | 2483,06 | 2005.09.20 |
| 120 | MV-010488 | Гоал тоавард майнинг | 50,2 | 2005.09.20 |
| 121 | MV-016660 | Зэст-Өндөр | 583,83 | 2010.09.21 |
| 122 | MV-019329 | Монголиан Лантаноиде Корпораци | 106,66 | 2015.09.21 |
| 123 | MV-019330 | Хан Алтайн тоосго | 25,94 | 2015.09.21 |
| 124 | XV-018666 | Оргилттэмүүлэл | 2287,91 | 2015.09.21 |
| 125 | XV-015148 | Ньюмандшир | 7120,27 | 2009.09.21 |
| 126 | XV-015149 | Геоканон төв | 27087,56 | 2009.09.21 |
| 127 | XV-017145 | Эс Пи Жи | 1441,27 | 2008.09.22 |
| 128 | XV-014177 | Хонгорхангай эрдэнэс | 69878,08 | 2008.09.22 |
| 129 | MV-010508 | Шандын нуруу | 257,17 | 2005.09.22 |
| 130 | MV-012048 | БИЛГҮҮНТРЕЙД | 23,97 | 2006.09.22 |
| 131 | MV-002613 | Гөүлдэннэст | 25,75 | 2000.09.22 |
| 132 | XV-010503 | Грийнривер | 11233,17 | 2005.09.22 |
| 133 | MV-016662 | Ди Эйч Пи Эн | 28,34 | 2010.09.22 |
| 134 | MV-014196 | Дримлэйнд | 353,54 | 2008.09.23 |
| 135 | MV-010511 | Ирмүүнзээрд | 1189,19 | 2005.09.23 |
| 136 | MV-015151 | Жи Би Эм | 78,67 | 2009.09.23 |
| 137 | MV-008469 | Хөхтөр | 76,08 | 2004.09.23 |
| 138 | XV-014192 | Ньютиара | 24993,78 | 2008.09.23 |
| 139 | MV-008468 | Хөхтөр | 74,98 | 2004.09.23 |
| 140 | XV-014195 | Ялгуун-Интернэйшнл | 107,55 | 2008.09.23 |
| 141 | XV-014193 | Цахирцагаан гол | 511,99 | 2008.09.23 |
| 142 | MV-015152 | Фокусметал майнинг | 30,92 | 2009.09.23 |
| 143 | XV-017843 | Далайнтогтох | 875,58 | 2015.09.24 |
| 144 | XV-014201 | Нутгийн гантиг | 507,13 | 2008.09.24 |
| 145 | MV-019331 | Тефис майнинг | 5488,42 | 2015.09.24 |
| 146 | XV-018258 | Улиастайчулуу | 4864,01 | 2015.09.24 |
| 147 | MV-017616 | Илчлэгхайлан | 39,33 | 2014.09.24 |
| 148 | XV-017748 | Их сүү | 6877,32 | 2015.09.24 |
| 149 | MV-017386 | Бэствайт | 103,86 | 2013.09.24 |
| 150 | XV-010526 | Андхуйшан | 36273,13 | 2005.09.24 |
| 151 | XV-018450 | Мөнхбичигт | 6945,72 | 2015.09.24 |
| 152 | MV-017615 | Жи Эф Си | 378,13 | 2014.09.24 |
| 153 | MV-011824 | Топруонхэнцо | 53,44 | 2001.09.24 |
| 154 | MV-015161 | Ловонко | 397,93 | 2009.09.24 |
| 155 | XV-012731 | МН ба ахас | 1669,84 | 2007.09.24 |
| 156 | XV-014552 | Сутайнтэргүүн | 33,43 | 2008.12.08 |
| 157 | XV-018981 | Говийн нар транс | 2120,55 | 2015.09.25 |
| 158 | XV-018362 | Хасбагана | 441,06 | 2015.09.25 |
| 159 | XV-015162 | Иххаан чулуу | 1407,59 | 2009.09.25 |
| 160 | XV-012053 | Бэрхресорсиз | 3682,72 | 2006.09.25 |
| 161 | MV-001356 | Хорих 443-р анги | 82,8 | 1998.09.25 |
| 162 | MV-012056 | Ордталст | 92,8 | 2006.09.25 |
| 163 | MV-012049 | Гуравт | 49,57 | 2006.09.25 |
| 164 | XV-012055 | Бэрхресорсиз | 2749,85 | 2006.09.25 |
| 165 | XV-018229 | Бугалуудконсалтинг | 256,98 | 2015.09.25 |
| 166 | XV-012051 | Алтандорнод монгол | 10540 | 2006.09.25 |
| 167 | XV-012050 | Алтандорнод монгол | 4356,34 | 2006.09.25 |
| 168 | XV-015591 | Цэнтрвилл | 12657,72 | 2007.09.26 |
| 169 | XV-014211 | Илчлэгхайлан | 50,72 | 2008.09.26 |
| 170 | MV-014209 | Энгүйтал | 692,42 | 2008.09.26 |
| 171 | MV-017387 | Оюут-Улаан | 6647,05 | 2013.09.27 |
| 172 | XV-012743 | Боролзой | 547,94 | 2007.09.27 |
| 173 | MV-017388 | Си Би Жи Эм | 319,72 | 2013.09.27 |
| 174 | MV-008479 | Гацуурт | 588,21 | 2004.09.27 |
| 175 | XV-012659 | Эн Эй Пи Эл | 645,73 | 2007.09.27 |
| 176 | MV-017389 | Минтекминералс | 683,61 | 2013.09.27 |
| 177 | XV-015387 | Эйч Би Си | 2341,45 | 2007.09.27 |
| 178 | XV-012759 | Наранбулаг шим | 3173,5 | 2007.09.27 |
| 179 | MV-008478 | Гацуурт | 120,83 | 2004.09.27 |
| 180 | MV-012756 | Си Эф Си групп | 25,73 | 2007.09.27 |
| 181 | MV-016664 | Сэлмандал | 135,02 | 2010.09.27 |
| 182 | XV-012753 | Эм Юу Си ресорсез | 112,86 | 2007.09.27 |
| 183 | MV-016668 | Түмэн-Анд | 451,25 | 2010.09.28 |
| 184 | MV-016669 | Түмэн-Анд | 154,46 | 2010.09.28 |
| 185 | MV-016920 | Түмэнцацал | 31,98 | 2010.09.28 |
| 186 | XV-019009 | СБЭБ | 1820,32 | 2015.09.28 |
| 187 | XV-019013 | Нүүрс хими | 2394,47 | 2015.09.28 |
| 188 | XV-018924 | Талын Монгол Групп | 5009,66 | 2015.09.28 |
| 189 | XV-018918 | Талын Монгол Групп | 30464,01 | 2015.09.28 |
| 190 | MV-001361 | Мон-Ажнай | 23,29 | 1998.09.29 |
| 191 | MV-014218 | Засаг сүмбэр | 59,44 | 2008.09.29 |
| 192 | MV-017617 | Майнтөмөр | 713,16 | 2014.09.29 |
| 193 | XV-014219 | Нью-Орем | 1237,17 | 2008.09.29 |
| 194 | XV-010532 | Их мөрөн шинэ ван | 1862,77 | 2005.09.29 |
| 195 | XV-010544 | АЭР зам | 1674,52 | 2005.09.29 |
| 196 | XV-012075 | Мартин майнинг | 185,92 | 2006.09.29 |
| 197 | MV-010551 | Бэрэнгрупп | 565,47 | 2005.09.29 |
| 198 | XV-017601 | АЭР зам | 785,49 | 2005.09.29 |
| 199 | XV-017600 | АЭР зам | 1557,21 | 2005.09.29 |
| 200 | XV-017602 | АЭР зам | 624,32 | 2005.09.29 |
| 201 | MV-015170 | Шинэсансар | 1684,89 | 2009.09.30 |
| 202 | MV-016921 | Асгат-Эрдэнэ | 25,11 | 2011.09.30 |
| 203 | MV-017392 | Идэрголд | 565,86 | 2013.09.30 |
| 204 | MV-016922 | Кайлонкуонеэ | 250,76 | 2011.09.30 |
| 205 | MV-000270 | Эрдэсналайх | 0,54 | 1995.09.30 |
| 206 | MV-015169 | Гаррисон-Ази | 469,83 | 2009.09.30 |
| 207 | XV-014231 | Баян өлзийт болд | 109,17 | 2008.09.30 |
| 208 | XV-018441 | Маунт шаста | 6287,32 | 2015.09.30 |
| 209 | XV-018474 | Юү И Ар Ти Си Эф Жи | 3223,5 | 2015.09.30 |
| 210 | XV-014999 | Эм Жи Эм Жи | 2607,67 | 2008.09.30 |
| 211 | XV-018923 | Оюу-Орд | 15333,46 | 2015.09.30 |
| 212 | MV-014228 | Илчитметалл | 65,54 | 2008.09.30 |
| 213 | XV-015167 | Айбекслэнд монголиа | 3272,7 | 2009.09.30 |
| 214 | MV-006364 | Нарийн гол гоулд | 364,88 | 2003.09.30 |

1. Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
   Төрийн сан банк 900000712 /Төгрөгийн/
2. Та холбогдох мэдээллээ http://mram.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3. Лавлагаа авахыг хүсвэл 263923 дугаарын утсанд хандана уу.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС**

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БАРЬЦААЛАГЧ БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

2016 оны 9 дүгээр сард ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу бүрэн төлж бүртгүүлэхийг хүсье.

| № | Код | Эзэмшигч | Барьцаалагч | Талбай (га) | Олгосон огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | MV-012756 | Си Эф Си групп | Анод банк | 25,73 | 2007.09.27 |
| 2 | XV-008323 | Монголцамхаг | Анод банк | 1418,42 | 2004.09.09 |
| 3 | MV-015152 | Фокусметал майнинг | Банк оф чайна | 30,92 | 2009.09.23 |
| 4 | MV-017392 | Идэрголд | Голомт банк | 565,86 | 2013.09.30 |
| 5 | XV-012028 | Цэвдэг | Капитал банк | 610,25 | 2006.09.19 |
| 6 | MV-001865 | Үүрттур | Капитал банк | 227,34 | 1999.09.17 |
| 7 | XV-014195 | Ялгуун-Интернэйшнл | Капитал банк | 107,55 | 2008.09.23 |
| 8 | MV-011979 | Монгол-Анар трейд | Капитал банк | 376,08 | 2006.09.04 |
| 9 | MV-012029 | Цэвдэг | Капитал банк | 139,05 | 2006.09.19 |
| 10 | MV-017100 | Авдарбаян | Лэтфорекс | 28,44 | 2002.09.19 |
| 11 | XV-012685 | Алкалли метал монголиа | Фёрст Литиум Корпорейшн | 12410,94 | 2007.09.06 |
| 12 | MV-017131 | Монлаа | Хаан банк | 585,55 | 2012.09.12 |
| 13 | MV-004878 | Монголросцветмет | Худалдаа хөгжлийн банк | 66,47 | 2002.09.17 |
| 14 | MV-016653 | Улз гол | Худалдаа хөгжлийн банк | 657,97 | 2010.09.09 |

1. Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
   Төрийн сан банк 900000712 /Төгрөгийн/
2. Та холбогдох мэдээллээ http://mram.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3. Лавлагаа авахыг хүсвэл 263923 дугаарын утсанд хандана уу.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС**

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Барилгын компаниудыг татварын бодлогоор дэмжинэ

Орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд 534 тэрбум төгрөгийн зарцуулалт, үр дүнд шалгалт хийх талаар Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр өчигдөр мэдээлэв.

Тэрээр өнгөрсөн дөрвөн жилд төрөөс барилгын компаниудад ямар хэмжээний зээл тусламж үзүүлснийг танилцуулахдаа ийнхүү хэлсэн юм. Орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанк арилжааны банкуудаар дамжуулан 101 компанид 534 тэрбум төгрөгийг зээл олгожээ. Үүнд, цемент, арматурын үнийг тогтворжуулах зориулгоор 55 компанид 125 тэрбум, Чингис бондын хөрөнгөөр инженерийн дэд бүтцийн 71 төсөлд 31.2 тэрбум төгрөг, цемент үйлдвэрлэлийн гурван төсөлд 180.3 тэрбум төгрөг багтжээ.

Барилгын салбарт нийт 4500 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ч дээрх зээл шаардлагатай компаниудаа хүрээгүй хэмээн сайд үзэж байгаа аж. Тэрбээр, "Зээлийг үйлдвэр бариагүй, 50 хүнтэй шинэ , шинэ компаниудад олгосон байна. Үүнийг багахан дэмжлэг үзүүлэхэд л хөл дээрээ босох хэмжээний чадвартай аж ахуйн нэгжүүдэд олгох ёстой байсан. Энэ зээл улсын төсвийг долоо хуваасны нэгтэй тэнцэнэ. Иймд шинэ Засгийн газар дахин хөрөнгө оруулалт хийхгүй, харин татварын бодлогоор дэмжиж, өмнөх зээлийн үр дүнг эргэж харна" хэмээв.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## МАНАЙ УЛСЫН ЗҮҮН ХЭСГИЙГ ХАР САЛХИ ДАЙРНА

Цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс маргааш буюу энэ сарын 2-нд манай орны зүүн хэсгийг хар салхи дайрч өнгөрөх талаар мэдээлжээ. Өнгөрөгч өдрүүдэд Японыг дайрч өнгөрсөн Тайфун хар салхи маргааш манай орныг дайрах аж. Энэ үеэр мөндөр, усархаг бороо орж, хүчтэй салхи салхилах төлөвтэй байгаа гэнэ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр Японы арлыг дайрч, Владивосток орчмоор эх газар дээр гарч ирэн эрч нь суларч, манай орны зүүн талд тулж ирэх бөгөөд аажмаар нутгийн зүүн өмнө тал руу шилжин есдүгээр сарын 3-ныг хүртэл байрлах юм байна. Гэхдээ арлын орнуудад нөлөөлдөг шиг хор хөнөөл манай оронд үзэгдэхгүй ч, 2-3 хоног усархаг бороо үргэлжлэн орж, салхины хүч 5-10 м/сек, зарим тохиолдолд 16-18 м/сек хүрэх тул болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэхийг ард иргэддээ анхааруулж байна.

МM-ИЙН ТОДРУУЛГА

# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА УХААЛАГ СИСТЕМД ШИЛЖИНЭ

Н.БАТЗАЯА

*"Ухаалаг цагдаа" төслийг энэ жилээс эхлэн хэрэгжүүлэхээр болсон билээ. Энэхүү төслийн талаар УЦЕГ-ын цагдаагийн дэслэгч М.Зоригтбаатараас зарим зүйлийг тодруулсан.*

**-Ухаалаг цагдаа хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу. Энэ төсөл ямар ач холбогдолтой вэ?**

-Улаанбаатар хотын цагдаагийн газраас Нийслэлийн мэдээллийн технологийн газартай хамтран "Ухаалаг цагдаа" төслийг хэрэгжүүлэхээр Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулсан. Үүний дараа уг төслийг хэрэгжүүлэхээр болсон. Энэхүү төсөл маань хоёр үе шаттай хэрэгжих юм. "Ухаалаг цагдаа" төсөл цагдаагийн байгууллагын хэсгийн байр, дэд хэсгийг интернэтийн сүлжээнд холбож улмаар гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж буй эмзэг цэгийг тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгч урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах зорилготой. Мөн бэлэн бус торгуулийн системийг нэвтрүүлэх, иргэн жолооч, тээврийн хэрэгсэл, эрэн сурвалжлалтын талаарх мэдээллийг шуурхай бүртгэх, дамжуулах, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ. Ер нь цагдаагийн алба хаагчдын ажлыг хөнгөвчлөх, хэргийг түргэн шуурхай бүртгэж, дамжуулах чухал ач холбогдолтой гэж ойлгож болно.

**-Хоёр үе шаттайгаар хэрэгжинэ гэлээ. Эхний удаад ямар ажил хийх вэ?**

-Тийм. Эхний удаа энэ онд Цагдаагийн 152 хороо, дэд хэсгийн байрыг нэгдсэн сүлжээнд холбоно. Мөн гэмт хэргийн орон зайн мэдээллийн систем болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний нэгдсэн хяналтын системийг суулгах юм. Үүний дараа 2017 онд уг төслийн хоёрдугаар үе эхэлнэ. Бид 2017 онд мэдээлэл дамжуулах цогц програм хангамжийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн төслийн дагуу "Ухаалаг цагдаа" мэдээлэл дамжуулах ухаалаг төхөөрөмжийг хэсгүүдэд суурилуулна. Ингэснээр цагдаагийн байгууллагын мэдээллийн үйл ажиллагаа ухаалаг системд шилжих юм. Дүн шинжилгээний системийг суурилуулах болно. Ийм хоёр үе шатыг дамжсанаар энэхүү төсөл бүрэн хэрэгжиж дууснa. Ер нь хороодын цагдаагийн хэлтэс нэгдсэн системд холбогдоогүй учраас цагдаа нар шаардлагатай мэдээллээ нийслэлийн цагдаагийн газар очиж авдаг. Үүнээс болж цаг их алддаг. Ухаалаг цагдаа төсөл хэрэгжсэнээр цагдаагийн алба хаагчид хэрэгцээт мэдээллээ мэдээллийн нэгдсэн сангаас цаг алдалгүй авах, гэмт хэргийн мэдээллээ шуурхай өгөх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, интернэтийн сүлжээтэй болно гэсэн үг.

**-Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээг нэгдсэн системд оруулна гэж байна. Тэгэхээр үйл ажиллагааг хянана гэсэн үг үү?**

-Нийслэлд үйлдэгдэж байгаа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх тусам нэмэгдэж байгаа. 2010 оноос 2015 оны хооронд 103.6 хувиар буюу хоёр дахин өссөн. Энэ нь хулгайн гэмт хэргийн замаар алдагдсан эд зүйл худалдан авч, зарж борлуулдаг ченж, ломбардуудын үйл ажиллагаатай холбоотой. Тиймээс цагдаагийн байгууллагаас хулгайлах гэмт хэргийн зах зээлийг судалж, дүн шинжилгээ хийсэн. Тэгэхэд гэмт хэргийн газраас алдагдсан эд зүйлсийн тодорхой хувь нь барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбардаар дамжуулан зах зээлд нийлүүлэгдэж байгаа нь тогтоогдсон. Иймд Улаанбаатар хотын цагдаагийн газраас НИТХ-аар "Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг батлуулсан. Энэхүү журмын хүрээнд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээнийнэгдсэнхяналтын системийг ажиллагаанд оруулж энэ төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах юм. Хамтарч ажиллана. Тэрнээс биш байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихгүй.

**-Төслөөс ямар үр дүнг харж байна вэ?**

-Товчхон хэлэхэд "Ухаалаг цагдаа" төсөл бидний үйл ажиллагаагаа сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад тусална. Ер нь цагдаагийн байгууллагын нэгдсэн сангаас цаг хугацаа алдалгүй сэжигтэн этгээд, тээврийн хэрэгсэл, жолоочийн бүртгэл мэдээлэл авдаг болно. Ингээд ирэхээр хэд хэдэн хүндрэл,бэрхшээлүүдалгаболж байгаа. Мөн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж буй эмзэг цэгүүдийг тодорхойлох боломжтой болох юм. Мэдээлэл дамжуулах цогц систем, ухаалаг төхөөрөмжийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр бэлэн бус торгууль ногдуулахаа болино. Торгуулийн систем хүртэл цахимд шилжинэ. Ер нь энэ төсөл маш олон ач холбогдолтой. Төслөөс сайн үр дүнгүүд гарна.

**-Хэзээнээс эхлэж хэрэгжих вэ?**

-Уг төсөл маань есдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН




*Төв аймгийн Баян, Баянжаргалан сум, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутгуудад малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын Ноогоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан, Нийслэлийн мал эмнэлгийн дарга А.Нарантуяа, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Гантулга болон бусад холбогдох албаны хүмүүс Мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд тавих хяналт, нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтэрч байгаа авто замуудын АТШБ товчоодын дэргэдэх ариутгал халдваргүйжүүлэлтийн цэгүүдэд ажиллалаа.*

## Зам тээврийн ослын улмаас таван хүүхэд гэмтжээ

Замын цагдаагийн газрын ЖШУХ-т өчигдөр зам тээврийн ослын 308 дуудлага бүртгэгджээ. Үүнээс 24 хүн хүнд, хөнгөн гэмтсэн бөгөөд бага насны таван хүүхэд зам тээврийн осолд өртсөн байна. Тодруулбал, Баянгол дүүргийн нутаг "Өргөө" кино театрын хойд замд амины N.Sunny маркийн автомашины жолооч Ө нь ганцаараа явж байсан, явган зорчигч зургаан настай хүүхдийг мөргөж, гэмтээжээ. Мөн Баянзүрх дүүргийн нутаг Дарь-эхийн нэгдүгээр гудамжинд T.Prius маркийн автомашины жолооч Б нь ганцаараа явж байсан таван настай Т-г мөргөж, гэмтээсэн хэрэг гарчээ. Тиймээс Замын цагдаагийн газраас бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхыг анхааруулжээ.

## Зуслан тонодог бүлэг этгээдийг баривчилжээ

Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн алба хаагчид зуслангийн ээнгүй байшинг тонож хулгай хийдэг бүлэг этгээдийг баривчилж, хулгайлан авсан эд зүйлсийг нь хураан авчээ. Тус бүсэд Ар хустай, Цээнэ, Цолмон, Гоодой, Баянбулаг, Бэлх, Хандгайт, Майхан толгой, Санзай Сэлбэ, Шарга морьт, Зуунмод зэрэг зуслангууд хамаарагдах аж. Цагдаагийн байгууллагаас зуслангийн байрнаасаа эд зүйлээ хулгайд алдсан бол Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст хандахыг сануулжээ.

## Хүчингүйд тооцов

Буян Маргад Од ХХК нь 5362318регистрийн дугаартай тамга гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Цагаан шилмүүс ХХК-ийн 5189527 регистрийн дугаартай, 9011134046 улсын бүртгэлтэй компани нэрээ өөрчилж байгаа тул хүчингүйд тооцов.

# БАРИЛГЫН САЛБАРЫГ ДЭМЖИЖ, ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь III нүүрт**

Харин уг тоо өнөөдрийн байдлаар 1425 нэмэгдсэн аж. Гэвч эдгээр компаниуд тусгай зөвшөөрлөө одоо болтол аваагүй байна. Тиймээс тусгай зөвшөөрлийг дахин олгоно гэдгийг салбарын сайд хэлж байлаа. Энэ үеэр хурлад оролцсон мэргэжилтнүүдтэй уулзаж, барилгын салбарын өнөөгийн байдал, түүнээс гарах арга замын талаар тэдний байр суурийг сонслоо.

### М.Батбаатар:110 компани 400 тэрбумын санхүүжилтаа аваагүй

*/Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч/*

-Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 110 гаруй компани Монголын барилгачдын холбоонд хандсан. Эдгээр компаниуд 400 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг төр болон захиалагч байгууллагаас авч чадаагүй. Түүнээс болж банкны урт, богино хугацааны зээл авч, түүнийгээ төлж чадахгүй байдалд орсон. Ийм гомдол санал манайд ирж байсан. Түүнээс 28 компани шүүхэд шилжиж, нэлээд урт хугацааны маргаан үүсгээд явж байна. Ер нь байгаа хөрөнгөө ломбард, хадгаламж зээлийн хоршоонд барьцаалан ажилчдынхаа цалинг тавьдаг иим хүнд байдалд орсон 100 орчим компани бий. Сая салбарын сайд барилгын компанийн зээлдэгчдийн уулзаж, асуудлыг шийдэж байна. Их хэмжээний зээл аваад төлөх хугацаа нь тулчихсан томоохон аж ахуйн нэгж, компанийн зээлийн хугацааг уртгасгах асуудлыг УИХ-д тавьж, шийдвэрлүүлэх боломжтой гэж хэлсэн. Миний хувьд хоёр жилийн өмнөөс л арилжааны банкуудыг уян хатан байгаачгэдэгсаналыгдэвшүүлсэн. Барилгын салбарын аж ахуйн нэгжийг чадал чансаатай байхад нь өндөр хүүтэй зээл өгчихөөд чадал чансаа, ажлын бүтээмж буурсан үед нь зээлийнхээ хүү, хүүгийн хүүг бодож, чангалдагаа болих хэрэгтэй. Хугацааг сунгах, хүүгийн хүүг зогсоох зэрэг янз бүрийн арга хэмжээ авч болно. Ийм асуудлыг байнга тавьдаг. Барилгын салбарыг уналтаас гаргахын тулд нэг хувийн татварын бодлогоор дэмжье гэж байна. Барилгын салбар хоорондоо өрийн сүлжээ үүссэн байгаа. Нэг нь барилга барьж, нөгөө нь материалыг нь хийдэг. Энэ хүмүүс мөнгө байхгүй болохоор бие биеэсээ зээлдэг. Өрийн сүлжээг тайлахын тулд хамгийн түрүүнд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хэрэгтэй.




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### 30 гаруй мянган айлын орон сууц зогсонг байдалд байна

-Өнөөдөр барилгын салбарт үүссэн хүндрэлтэй байдлыг давахын тулд Барилга, хот байгуулалтын яам Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тодорхой асуудал тусгаж, түүнийгээ хэрэгжүүлэх үндсэн чиглэлээ салбарынхандаа дуулгаж байна. Манай салбарт хэд хэдэн асуудал бий. Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр хумигдсан. Барилгын салбарт 30 гаруй мянган айлын орон сууц баригдсан боловч зогсонго байдалд орсон. Энэ цаанаа ямар учиртай вэ гэвэл барилга барихын тулд гол төлөв өндөр хүүтэй зээл авдаг. Энэ нь эдийн засгийн хүндрэлд улам ачаа болж байгаа талтай. Үүнтэй холбоотой. Тэгэхээр энэ байдлаас гарахын тулд найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ гэдэг засгийн газрын байр суурь бий. Мөн барилгын компаниуд орон сууцны барилга, барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр олгосон банкны зээлийн хүүг уртасгая, боломж байвал зээлийн хүүг тодорхой хэмжээгээр бууруулъя гэдэг чиглэлээр судалгаа хийж байна. Ойрын хугацаанд энэ чиглэлээр шийдвэр гаргана. Харин хэрхэхийг Засгийн газар шийдэх байх.

NO STRESS



# Эрдмийн өргөөнд эхний ХОНХ ЦАНГИНАЛАА

Хичээлийн шинэ жил эхэллээ. Эх орны маань өнцөг булан бүрт  эрдмийн өргөөний өмнө хүүхэд залуусын дуу цангинаастай. Зуны гурван сарын турш ангийн нөхдөө санаж үгүйлсэн сахилгагүй жаалууд, дүрэмт хувцсаа цэвэрхэн гэгч нь өмсч, гэзгэндээ цагаан өнгийн туузыг чамин гэгч нь зангидсан хөөрхөн охид, ижилдэн нассан найз нөхөд, багш, эрдмийн саруул өргөө рүүгээ яаран алхах оюутан залуус. Энэ бол есдүгээр сарын 1-ний гэгээн дүр зураг.  Аав ээжийнхээ өврөөс салаагүй зургаан настнууд ч тэдний төлөөлөл билээ.  Цэцэрлэгийн намхан ширээ, сонирхолтой тоглоомноосоо салж, сургуулийн сурагч болж буй тэд энэ өдрийн бас нэгэн өхөөрдөм дүр.  Тэдний зарим нь эцэг эхээ даган мэгшиж, харин зарим нь эрдмийн өргөөндөө аль хэдийнэ тухлана.  Эх орны өнцөг булан бүрт ийм дүр зураг хөвөрлөө.  Тун удахгүй тэд эх орны хөгжлийн төлөө ажиллах ирээдүйн эрдэмтэд болно.




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН















